

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-41

---

1.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан мэдээлэл сонсох	5-41
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 4 дүгээр сарын 07-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Алтангэрэл, С.Амарсайхан, Э.Батшугар, Ж.Баярмаа, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар, С.Эрдэнэболд;  
Тасалсан: Х.Баттулга.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас Хууль зүй, дотоод хэргийн сайдын хүсэлтээр хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	6
Бүгд:	17

64.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хасав.

**Нэг.Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, мөн газрын ахлах референт Ш.Цэцэг-Өлзий, Д.Бямбадулам, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Мөнхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Ш.Батбаяр, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Бат-Өлзий, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Баянзул, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга И.Лувсанцэрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан, Соёлын өвийн хэлтсийн дарга Б.Даваацэрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баярмагнай, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Д.Туяа, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, мөн газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, Г.Нямдэлгэр, Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ү.Ганболд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, мөн газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Даваадалай, мөн компанийн Эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Бүсчилсэн хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал Д.Эрдэнэбаяр, Удирдлагын академийн багш Н.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Баярбаатар, Н.Алтанхуяг, О.Номинчимэг, Х.Баасанжаргал, С.Одонтуяа, Д.Пүрэвдаваа, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Батбаяр, Гэр бүл,

хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Баярбаатар, Х.Баасанжаргал, Х.Тэмүүжин, Д.Пүрэвдаваа, Д.Ганбат, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг сонсов.

*Уг асуудлыг 12 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 05 минут үргэлжилж, 27 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 70.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 30 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 38 минут

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе ээ. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц 55.6 хувьтайгаар хүрсэн байна. Ирцэд орсон гишүүд Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнайн Баярбаатар, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Гонгорын Дамдинням, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Буяагийн Тулга, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна аа.

Ингээд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 2 асуудал хэлэлцэхээр уг нь төлөвлөсөн байгаа.

Нэгдүгээр асуудал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль шинэчилсэн найруулга байгаа. Хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа. Хэлэлцэх эсэх асуудал байж байгаа.

Хоёр дахь нь хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан гэсэн ийм 2 асуудал байна. Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Алга байна.

Тэгэхээр би энэ дээр нэг санал гаргахыг хүсэж байна. Тэгээд гишүүдийгээ дэмжээд өгөөсэй гэж хүсэж байгаа юм аа. Энэ 1 дүгээр асуудал дээр Хууль зүйн сайд өөрөө над руу ярьсан. Тэгээд энийг нэг 7 хоногоор хойшлуулж өгөөч. Бас энэн дээр өөрөө ажилтайгаа танилцаад эргээд надтай бас ярьж зөвлөлдөх ганц 2 асуудал байна гэдэг асуудал тавьсан учраас би бас энэ зүй ёсны асуудал байна. Өөрөө бас асуудалтайгаа нарийвчилж танилцъя гэж байгаа юм байна. Тэгээд энэн дээр дараагийн хурал хүртэл хойшлуулах ийм горимын санал гаргаж байна аа.

Манай гишүүд санал хураалтад бэлдье.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудлаас Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай шинэчилсэн найруулгын төсөл болон хамт

өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64.7 хувиар санал дэмжигдлээ. Ингээд асуудал хойшлогдлоо.

Ингээд дараагийн асуудалдаа ороод явъя.

### ***Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн талаар***

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16.1-д Улсын Их Хурлаас Засгийн газар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагад хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ээлжит чуулган эхлэхээс 15 хоногийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ гэж, 16.2-т Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг ирүүлснээс хойш 15 хоногийн дотор Тамгын газар, Байнгын хорооны эрхлэх асуудал бүрээр дүн шинжилгээ хийж танилцуулгын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж тус тус заасны дагуу 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хурлын ЕНБД-аас Хууль зүйн байнгын хороонд танилцуулга хүргүүлэх тухай албан тоогоор Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд хууль Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дүн шинжилгээ хийж ирүүлснийг та бүхэнд цахимаар болон шуудангаар тараасан байгаа.

Хууль тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн талаарх тайланг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Баттөмөрийн Энхбаяр танилцуулна аа. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Эрхэм байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журмын 6-д заасны дагуу цахим системд хяналтад байгаа Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хамаарах 49 шийдвэрийн 341 заалтын биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна аа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн санд ирүүлсэн тайлан мэдээллийн их өгөгдлийн дата баазыг ашиглаж хийсэн бөгөөд анхан шатын нэгж, сум, дүүрэг, аймаг, нийслэл, агентлаг, яам ЗГХЭГ-аас шат дараалсан үнэлгээний тайлан нэгтгэсэн үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Энэ үйл явцад яам, агентлаг, орон нутгийн төлөөллийг оролцуулснаас гадна Канадын Мерит төсөл, Юнисеф, Удирдлагын академийн зөвлөхүүдийн арга зүйн дэмжлэг зөвлөмж саналыг тусган ажилласан нь анх удаа бүх шатын оролцоог хангасан арга хэмжээ боллоо.

Мөн ажлын бүтээмж үр дүнг нэмэгдүүлэх технологийн дэвшлийг ашиглаж тус Байнгын хороонд хамаарах шийдвэрүүдийн биелэлтэд хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийж үзсэн болно оо.

2025 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 49 шийдвэрийн 341 заалтыг яам, агентлаг, аймаг, нийслэлд хэрэгжүүлж ажилласан бөгөөд биелэлтийн дундаж 82.7 хувьтай байна. Нийт 210 заалт хэрэгжсэн, 78 заалт хэрэгжих шатад, 18 заалт хэрэгжээгүй, 15 заалт хугацаа болоогүй, 20 заалт хэрэгжих боломжгүй гэж үнэлэгдсэн байна.

2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, тухайн шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 210 заалтыг Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн сангийн сангийн хяналтаас хасах үндэслэлтэй гэж үзэж Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна аа.

Тайлан тоонд хэрэгжээгүй шийдвэрүүд нь төрийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэгдэж байна. Тухайлбал төрийн байгууллагуудын түвшинд хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдэж чадаагүй, салбар хоорондын ажлын уялдаа сул олон удаагийн бүтцийн өөрчлөлт хийгддэг, төсөв хөрөнгө, зохицуулалт, оруулалтын эрэмбэ дараалал хангалтгүй бодлогын болон хүний нөөцийн тогтворгүй байдал зэрэг нь хууль тогтоомжийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн 2025 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын гишүүн Засгийн газрын агентлагийн дарга аймаг НЗД нарт дараах арга хэмжээг авахыг даалгасан. Үүнд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж салбар хоорондын уялдааг ханган бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх.

Салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдийн ахуй амьдрал болон салбар хөгжлийн үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж буйг үнэлж тооцож ажиллах. Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт, утга агуулгын давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх, санхүүгийн эх үүсвэрийг тусгах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарах. Дижитал хяналт их өгөгдөлд суурилсан үнэлгээ хийх хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтийг бодит цагт хянах, ил тод болгох чиглэлээр цахим шинэчлэл хийх санал боловсруулж танилцуулах.

Мөн хууль тогтоомжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнууд зөвлөмж хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын даргад даалгасан болно оо. Цаашид Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт шинэчлэлтийн талаар баримтлах бодлогыг эргэн харах, шинэчлэх, сайжруулах үндэслэл бий болсныг харуулж байгааг дурдах нь зүйтэй.

Хууль тогтоомжийн биелэлттэй холбоотойгоор Улсын Их Хурлын түвшинд анхаарах дараах асуудлууд байна. Нэг Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог сонгогддог байгууллагуудад үүрэг даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах үйл ажиллагааг гүйцэтгэлийн байгууллагуудын түвшинд уялдуулах нэгдсэн байдлаар тайлагнах боломжийг бүрдүүлэх.

2.Улсын Их Хуралд гарч байгаа шийдвэрийн талаар нэгдсэн бүртгэлийн систем үүсгэж Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн сантай уялдуулах, гарч байгаа шийдвэрийг шуурхай дамжуулах хяналтад авах Улсын Их Хурлын байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдийн шинэ түвшинд шийдвэрийн хэрэгжилтийн явцыг цахим систем ашиглан улирал тутам танилцах боломжтой болгох, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил болон тухайн жилдээ бүрэн хэрэгжсэн болон бусад шалтгаанаар хяналтаас хасуулах шийдвэр заалтын талаар Засгийн газартай тогтмол хамтарч ажиллах.

Хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хороодын шийдвэр Засгийн газрын бодлогын баримт бичигт заасан зарим заалт агуулгын хувьд давхцах, хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин тогтоол хэлбэрээр албажуулах зэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зэрэг болно оо.

Тус Байнгын хороонд хамаарах шийдвэрийн биелэлтэд анх удаа хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийсэн бөгөөд нийт 342 заалтын 0.9 хувь нь хуулиар ноогдуулсан чиг үүргийг дахин үүрэгжүүлсэн заалт байна. 2.6-39.8 хувь нь Тогтоолын хэрэгжилтийг давтан баталгаажуулсан заалт байна. 6.1 хувь нь бодлогын баримт бичигтэй агуулгын огтлолцолтой заалт тус тус эзэлж байна аа.

Цаашид Улсын Их Хурлын холбогдох бүтцийн нэгжтэй хамтран хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийх ажлыг улам боловсронгуй болгох, Улсын Их Хурлаар гарч байгаа шийдвэрийн биелэлт, үр нөлөө, хяналтыг сайжруулахаар зорьж ажиллаж байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хамаарах хууль тогтоолын биелэлтийн 2025 оны жилийн эцсийн хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийг хавсаргасан болно оо. Баярлалаа.

#### **Д.Цогтбаатар:** Энхбаяр сайд танилцуулаад дууссан уу?

Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Би эхнээс нь уншаад энэ төрийн нарийнуудыг нь дуусгаад ер нь зогсёе. Яагаад гэвэл энэ уншиж дуусгана гэвэл маш олон хүн энд оролцож байгаа учраас би энэ дээр нь зогсоод явчихъя гэж бодож байна. Манайхан бас зөв ойлгоорой гэж бодож байна. Цагаа бодъё ажлын цагаа. Энд ингээд ажлын хэсэгт орсон байгаа гишүүдийг танилцуулъя.

ЗГХЭГ-ын дарга Монгол Улсын сайд Б.Энхбаяр, ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын дарга Ч.Бат-Эрдэнэ, ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын Засгийн газрын ахлах референт Ш.Цэцэг-Өлзий, ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын Засгийн газрын ахлах референт Д.Бямбадулам, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярмагнай, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болор-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн

дарга Т.Жамбалцэрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Ерэн-Өлзий. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмарнаран, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул болон бусад албан тушаалтнууд энд оролцож байна аа.

Манай Улсын Их Хурлын зүгээс бол Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын зөвлөх Б.Алтантуяа, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт Г.Нямдэлгэр гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг оролцож байна аа.

Ингээд ажлын хэсгийг танилцуулж дууслаа.

Тэгээд холбогдох саяын нэр дурдсан бүх төрийн нарийнууд энд ирчихсэн байж байгаа тийм биз. Тэгвэл ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Пүрэвдаваа гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе ээ. Нэг ийм тайланг нэг хэлчихсэн болоод л нэг үр дүнгүй шахуу л юм яваад байгаа юм аа. Тэгээд тайлагнаж байгаа болоод хяналтад авч байгаа асуудал нь нэг тийм инээдтэй. Нэг хуулиар ийм дүрэм журам гаргах зөвлөл батлах байсан чинь батлаагүй доо хүртэл гээд. Энд ерөөсөө чухал биш байхгүй юу даа. Уг нь бас олон жил л хэлээд байгаа юм. Анх энэ Засгийн газар дээр энэ хяналт шинжилгээний журам батлахад бас нэг арай өөрөөр авч үзье гээд. Улсын Их Хуралд энэ дүрэм журам батлагдсан эсэх гэдэг тайлагнахаасаа илүүтэй магадгүй энэ хуулийн хэрэгжилт нь нийгэмд ийм эерэг нөлөө авчирлаа ийм сөрөг нөлөө авчирлаа. Ингэж бас татвар дээр ачаалал үүсгэж байна. Эсвэл хүний эрхийг ингэж дээрдүүлж байна, бид олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ ингэж биелүүлж байна гэж тайлагнамаар байна.

Та нарын одоо хуулиа хэрэгжүүлж чадаагүй ажлыг бид энд сонсоод яадаг юм. Ер нь нэг зөвлөл баталж чадаагүй журам баталж чадаагүй.

Тэгэхээр Цогоо дарга энэ ерөөсөө анхнаасаа бас энэ Хууль зүйн байнгын хороо Улсын Их Хурал дээр энийгээ нэг авч үзэхгүй бол энэ ерөөсөө ингээд үр дүнгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр бид хэд энэ хуулийн нөгөө эерэг сөрөг эффект ер нь юу болов оо гэдэг зүйлийг л авч үздэг баймаар байна. Энэ хуулийг цаашдаа яах юм бодлогын хүрээнд гэж ярихгүй бол одоо энийг хар л даа инээдтэй байгаа биз дээ.

Тийм журмуудыг баталж чадаагүй, одоо хүртэл батлаагүй. Ийм юм яриад сууж байна гэдэг чинь бид нар нэг талдаа харамсалтай байхгүй юу даа. Тэгэхээр энийг уг нь Ерөнхий сайдын дэргэд хууль тогтоомжийн агентлаг байгуулъя гээд байгаа чинь ерөөсөө л энэ. Тэгээд Ерөнхий сайд чинь Улсын Их Хурал дээр хууль тогтоомжийн биелэлтийг өөрийнхөө хариуцаж байгаагийн хувьд бид нарт тэгж тайлагнана, сайд нараасаа танай салбарын хуулиуд чинь ингэж эдийн засгийг

боомилж байгаа юм байна, чөдөр болж байгаа юм байна хүний эрхийг ингэж дордуулж байгаа юм байна гэж ярих ёстой байхгүй юу. Тэгэхгүй ингээд хар даа тийм журмаа батлаагүй байна, ийм журмаа батлаагүй байна энэ чинь шал инээдтэй.

Ингэж төрийн ажлыг хэдүүлээ халтуурдахаа больё оо залуучууд аа. Жоохон өөрчлөөч ээ. Би энийг ингээд Улсын Их Хурал дээр 4 дэх улирал явж байна 4 дэх улирал болгон дээр яг ингэж хэлээд өөрчлөгддөггүй. Тэгээд нэг үр дүнгүй. Орж ирээд нэг ийм формалный баахан хурал явчихдаг. Энийгээ давтаад нэг хэлчихье.

Тэгээд 1 тоймтой юм асууя. Олон улсын гэрээ конвенцуудын орчуулгаас эхлээд алдаатай байгаа энийг нэг компаничилж нэг засъя гэж байгаа. Засъя гэж байгаа. Нэр томъёонуудыг нь бид нар бас жоохон агуулгыг нь буруу ойлгоод орчуулчихсан зүйлүүд байгаад байгаа.

Хоёрдугаарт энэ UPR ч гэдэг юм уу энэ олон улсын гэрээ конвенцуудыг тайлагнахдаа хүнтэйгээ хамт тайлан алга болчихдог. Тэгэхээр уг нь энийг Монгол Улсын нэгдэн орсноос хойш бүх тайлангуудаа яагаад олон улсаас өгсөн зөвлөмж дүгнэлт, хэлэлцүүлгүүдийг ингээд жагсаагаад аль төрийн институц энэ дээр нь үүрэг хүлээж тайланг нь гаргаж байгаа хэрэгжүүлж байгаа гэдэг ийм мэдээллийн нэг сан бүрдүүлчихье гээд тухайн үеийн гишүүн Цэндийн Мөнх-Оргил гишүүнээр ахлаад бид хэд ингээд ярьж байсан юм. Тэгээд гадаад хэргийн яам амлалт аваад бид хэд энийг мэдээллийн сан үүсгээд.

**Д.Цогтбаатар:** Микрофон Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

Тэр ажил маань хаана явна аа? Тэгчихвэл хүнтэйгээ ажил явахгүй ээ. Бид хэд ингэж ОУБ-д дандаа давтамжтай худлаа хэлдгээ мартчихна. Үгүй байхгүй болчихно гэсэн үг. Бид хэд нэг баахан амлалт авчхаад дараа нь дахиад өөр юм ярьдаг юм. Нөгөөдүүлд архив нь байгаад байдаг бид хэд болохоороо энд ярьсан хэлсэн зүйлээ мэддэггүй байхгүй юу. Энэ юу болж байна?

Хоёрдугаарт тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу нэлээн олон хууль тогтоомжийг өөрчлөх ажлыг Засгийн газарт даалгасан. Тэр хаана явна аа? Хэн хариуцах вэ? Хэчнээн хууль нь орж ирээд хэчнээн нь орж ирээгүй байна вэ? Энэ дээр нэг тоймтой хариу өгөөдхөөч ээ. Тэгээд бид хэд энэ цаашдаа Энхбаяр сайд ажлаа аваад одоо ганц нэг ийм төрийн бүтээмжийн энэ асуудал дээр нэг зөв болгочхооч. Хэдүүлээ ингэж хар даа тийм дүрэм журам батлагдсан гэхээсээ илүүтэйгээр энэ хуулиар ямар үр нөлөө авчрав гэдэг зүйлүүдийг ярьдаг байх юм бол бодлогын асуудлууд маань энд ч гэсэн цэгцрээд гарна. Бид хэд энэ рүүгээ анхаарах юм байна гээд. Тэгээд тэр дүрэм журам гарснаараа үнэхээр эерэг байгаа юм уу сөрөг байгаа юм уу мэдэхгүй байгаад байна шүү дээ ийм зүйл байна. Тэгээд саяын тэр 2 асуултад яг тодорхой хариулаад өгөөч.

**Д.Цогтбаатар:** 3 дугаар микрофон Гадаад яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг.

**Л.Мөнхтүшиг:** ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг. Сайнзориг гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр олон улсын гэрээ конвенцын хэрэгжилттэй холбоотой асуудал байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр өнгөрсөн хугацаанд Мөнх-Оргил сайдын үед болон

бас хийж байсан ажлууд байдаг. Тэгээд яг сая гишүүний хэлсэнчлэн энийг компани ажил болгож бүх төрийн институцийг нэг чиглэлд нь оруулахгүй бол зөвхөн ГХЯ-ан дээр олон улсын гэрээ хэрэгжилт байдаг гэдэг нь өөрөө хангалтгүй байгаа. Тэгэхээр Хууль зүйн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу 2 жилдээ нэг удаа Монгол Улсын олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүрэг тэр дундаа хүний эрх аюулгүй байдалтай холбоотой гэрээ конвенцын хэрэгжилтийг сонсдог энэ шинэ горимд шилжих гэж байгаа энэ бэлтгэлийг бас Засгийн газрын түвшинд хангаад явж байна. Яг гэрээтэй холбоотой асуудлыг Гадаад харилцааны яам бусад байгууллагуудтай хамтраад хийж эхлүүлчихсэн байгаа. Энэ хүрээндээ олон улсын гэрээний цахим санг байгуулах Засгийн газрын бас шийдвэр гарчихсан. Энэний дагуу ажлууд нь хийгдээд явж байна. Тэгээд ер нь бол энэ дээр бас шүүхийн байгууллагуудтайгаа бас хамтарч ажиллахгүй бол хэдийгээр бид нар олон улсын гэрээнд нэгдэж ороод байдаг боловч яг Моннис зарчим бол Монголд бас хэрэгжиж байна уу, олон олон улсын гэрээ маань хэрэгжиж байгаа юу үгүй юу гэдэг нь өөрөө маш том асуудал болчихоод байгаа.

Тэгэхээр төрийн мэдээллийг хэвлэдэг хэвлэлийн санхүүжилтийг бас хариуцдаг энэ асуудлуудыг маш тодорхой болгохгүй болохоор бид нар гэрээгээ соёрхон баталчхаад төрийн мэдээллээ хэвлэхгүй байгаа ийм асуудал байгаа. UPR-тай холбоотой буюу Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын асуудлын талаар өнгөрсөн онд бид нар 11 дүгээр сард НҮБ, Хүний эрхий зөвлөл тайлангаа хамгаалсан. Тэгэхээр энэ жилээс эхлээд бид нар тайлангаа хамгаалсан даруйдаа төрийн бусад байгууллагын яамандаа үүрэгжүүлээд явдаг. Энэ хамгаалсан тайлан зөвлөмжүүдийгээ бид Засгийн газрын хуралдаанд танилцуулаад бүх байгууллагад ерөнхий төлөвлөгөө гаргаад дөнгөж саяхан батлуулчхаад ингээд явж байгаа. Өнгөрсөн удаа бол бас жоохон хугацаа алдсан юм байна лээ. Цаашдаа энийгээ жигдрүүлээд явах дээр Гадаад харилцааны онцгой анхаарч байгаа. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** 4 дүгээр микрофон.

**Н.Мягмар:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя аа. Энэ Гадаад яамны Төрийн нарийн бичгийн даргын өгсөн мэдээлэл дээр нэмж тодруулахад энэ олон улсын гэрээ конвенцын нэр томъёоны орчуулга алдаатайгаас болоод энэ асуудлууд бас Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам энэ конвенцыг хэрэглэж байгаа байгууллагуудын хооронд бол бас ажил хэргийн уулзалтуудыг зохион байгуулсан. Өөрөөр хэлэх юм бол нэр томъёог зөв болгоод орчуулах гэхлээр агуулга руу нэлээд өөрчлөлт ороод байгаа учраас эргээд тэр агуулга нь эргээд хууль зүйн үр дагавар үүсгээд байгаа учраас энийг бол техникийн шинжтэй буюу Засгийн газрын түвшинд энэ орчуулгыг нь янзлаад ингэх бололцоо байхгүй. Төрийн мэдээлэлд нь хэвлэчихсэн учраас.

Тийм учраас энэ олон улсын гэрээний хуульд өөрчлөлт оруулаад энэ Сайнзориг гишүүний хэлж байгаагаар орчуулгын энэ алдаатай байдлыг хийх тохиолдолд Засгийн газарт эрх олгох байдлаар ингэчих юм бол энийг нь Засгийн газрын түвшиндээ орчуулгаа хянан баталгаажуулах.

**Д.Цогтбаатар:** Гүйцээгээд хариулах уу? 4 дүгээр микрофон.

**Н.Мягмар:** Гадаад яам, Хууль зүйн яам 2 бол гэрээг олон улсын гэрээний орчуулгыг хянан баталгаажуулах энэ 2 сайдын хамтарсан журмаараа явж байдаг. Тэгэхээр энэ хүрээндээ энэ орчуулгыг дахин хянаад ингээд төрийн мэдээлэлд

шинэчилж хэвлүүлэх энэ ажлыг хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай юм байна гэдэг бол ажил хэргийн уулзалт үеэр тогтож байсан.

Таны дурдсан бас энэ конвенцын тайлангийн мэдээллийн энэ сан байгуулахтай холбоотой асуудал бол үнэхээр яах аргагүй тулгамдаж байгаа асуудал байгаа юм. Энэ олон улсын гэрээ конвенцын хэрэгжилтийг хариуцсан тайланг хариуцсан хэд хэдэн яамдууд байдаг. Хөдөлмөрийн яам, Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам ч гэдэг юм уу Хууль зүйн яамнаас гадна.

Тэгэхээр энэ конвенцуудын тайлан мэдээллийг Засгийн газрын тайлан мэдээлэл тогтоол шийдвэрийн биелэлтийг хүлээж авдаг энэ систем дээр тулгуурлаад Хэрэг эрхлэх газар дээр нэгтгээд ингэж явбал яасан юм бэ гэдэг саналыг бол Хэрэг эрхлэх газартаа ХЗДХЯ-аас хүргүүлчихсэн. Ингээд энийг бол бас ажил хэрэг болгоно.

**Д.Цогтбаатар:** Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Мягмар дарга аа. Тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой нөгөө хууль тогтоомжууд хаана байна тэрийгээ л нэг хариулаадхаач. Тэгээд миний зорилгыг та хэд маань ойлгохгүй байна аа? Би зөвхөн UPR яриагүй байхгүй юу. Энэ нэгдэж орчхоод байгаа олон улсын гэрээ конвенцуудын чинь заалт болгоны дагуу бид хэд үүрэг хүлээж байгаа. Энэ тайлагналтын явцад энэ яг тухайн заалт болгон дээр гишүүн орнуудаас өгсөн зөвлөмжүүд байдаг. Зөвлөмжийн хэрэгжилтүүдийг ямар байдлаар явж байгаа гээд. Яг энийг бид нар мэдээллийн сан үүсгэх юм бол тогтмол мэдээллээ нэг зөрөөгүйгээр тайлагнахаасаа гадна ядаж манай энэ дотоодын статистик гаргах юм чинь цэгцрэх гээд байгаа юм. Одоо жишээ нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн конвенц дээр тэгдэг байхгүй юу. Хэчнээн хөгжлийн бэрхшээлтэй иргэд хууль зүйн туслалцаа авсан бэ гэхээр бид нар механик аргаар түүдэг шүү дээ. Ядаж энийгээ ингээд яачих юм бол салбарууд чинь хүртэл ингээд мэдээллийн сангаа гаргах юмнууд чинь цэгцрээд явах гээд байгаа юм аа.

Тэгээд энэ хуулийг нь биччихсэн байгаа шүү дээ Мягмар дарга аа.

Наадах чинь бүүр ингээд аль хэзээний бичээд ингээд ерөөсөө ажил явахгүй. 4, 5 жилийн өмнө ингээд бичээд тавьчихсан хууль одоо хүртэл орж ирэхгүй. Ингээд юмаа цэгцэлж.

**Д.Цогтбаатар:** Яах вэ гүйцээж хариулах уу? Асуучих даа. Тэр Үндсэн хуультай холбогдсон асуултад нь Мягмар дарга хариулъя.

**Н.Мягмар:** Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулаад Үндсэн хуулийн өөрчлөлтийг нийцүүлж хууль тогтоомжийг өөрчлөх үүргийг бол Засгийн газарт Улсын Их Хурлаас өгсөн. Энэний дагуу бол холбогдох яамдууд бол өөр өөрсдийнхөө чиглэлээр Үндсэн хуульд нийцүүлэх ажлуудыг хийж байгаа гэж ойлгож байгаа. ХЗДХЯ-нд эрхлэх асуудлынхаа хүрээнд салбарын яамнуудаас хууль тогтоомжийн үзэл баримтлалын төслөө ирүүлэх тохиолдолд Хууль зүйн яам бол энийг нь үзэж хянаад үзэл баримтлалыг батлаад ингээд явж байгаа. Одоо хамгийн гол зүйл бол энэ 6.2-той холбогдуулаад Ашигт малтмалын хууль шинэчилсэн найруулга бол нэлээн хүлээгдэж байгаа. Хот тосгоны хуулиудын дагуу хот тосгон байгуулах асуудлууд ингээд бас яригдаж байгаа.

Энэ мэтчилэн бол үе шаттай энэ эрхэлсэн яамдууд хариуцсан сайдуудаас бол үзэл баримтлал, хуулийн төслөө боловсруулаад ирэхэд бол Хууль зүйн яам оролцоод явж байгаа.

**Д.Цогтбаатар:** Энэ дээр Сайнзориг гишүүний түрүүний хэлдэг тэр орчуулгын асуудлыг ярихын тулд бүүр нарийн зүгээр энэ орчуулгын асуудал биш байхгүй юу. Нөгөө эрх зүйн цаанаа агуулгын асуудал байгаа болохлоор энэ бүүр судалгаа хийж байж яахгүй бол та нар өөрсдөө гайх нь. Жишээлбэл НҮБ гэдэг чинь монгол хэл дээрээ буруу орчуулгатай байгаа байхгүй юу. Англи хэл дээрээ нэйшн гэдэг чинь нэйшн стэйт гэж хэлсэн болохоос биш нэйшн нэшналити гэдгийг хэлээгүй. Бид нар тэрийг нь үндэстэн гээд орчуулчихсан үндэстнээр нь ярих юм бол Тажик үндэстэн чинь Тажикистанд болон Афганистанд амьдарч байна шүү дээ. Ингээд хил дамначихсан тэгээд тэр үндэстнийг гэж ярих юм бол энэ чинь жинхэнэ орчин үеийн улс гүрнүүдийн хоорондын харилцаанд маш том. Энэ бүр бүх үндэстэн дээр гарна гэх мэт. Ингээд энийг үнэхээр нарийн судалж хийх ёстой. Энхбаяр сайдад харин хандаж хэлэхэд саяын энэ Сайнзориг гишүүний үр дүнтэй байх ёстой шүү энэ хэлэлцүүлэг юмнууд чинь гээд үр дүнд чиглэсэн ийм ажиллагаатай байх ёстой гээд яг энэнтэй холбогдуулаад энэ Хяналт шалгалтын хуультай холбогдуулаад Энхбаяр сайдаа нэг юм хэлмээр байна. Одоо та энд ингээд бүх хүмүүсээ аваад ороод ирчихсэн. 11 Байнгын хороогоор ингээд хэрэггүй шүү. Яагаад гэвэл сая би энэ хуулийг харж байхад 2 зүйлийг нь яг нийлүүлээд хоршуулаад тайлбарлахад одоо бид нар дээр ч гэсэн энэ олон дарга нар хэрэггүй. Яг манай салбарын нөгөө дүн шинжилгээгээ хийгээд манай юм ороод ирчихсэн байж байгаа байхгүй юу.

Харин тийм тэгэхээр та энэ хүмүүсийн ажлын цагийг бараад дуусаж байгаа байхгүй юу. Эндээс зөндөө хүмүүсээс нь манай хүмүүс юм асуухгүй. Бид Байнгын хорооныхоо хүрээнд л юм асууна. Тэгэхлээр та Хууль зүйн байнгын хорооны зүгээс энэ юуг би хэлж байна шүү. Та энийг тэгэхлээр дараа дараагийнхаа юун дээр Их Хурлын удирдлагатай ч гэсэн яриад, би дэмжээд өгнө. Тэгээд яг тэгж яваарай.

Энэ хүмүүсийн ажлын цаг чинь бүүр баларч байгаа шүү дээ.

Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ. Би бол өнгөрсөн 2025 оныхоосоо бас дээрдэж орж ирсэн байна гэж харж байна. Тэгээд парламент үндсэн 3 эрхтэй. Төлөөлөх, хууль батлах, хяналт хэрэгжүүлэх гэсэн үндсэн 3 эрхтэй. Тэгээд үүний нэг чиг үүрэг бол энэ хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг бид нар энэ 2018 оноос хойш энэ парламентын хяналтыг сайжруулж хууль эрх зүйн орчныг нь бий болгож өнөөдөр бас нэг үеэ бодвол бас чиг үүргээ хангалттай гайгүй хэрэгжүүлээд явж байгаа болов уу гэж бодож байна. Тэгээд сая яах вэ гишүүдийн хэлсэнтэй санал нэг байгаа юм. Тэрэн дээр юу байна вэ гэхээр бид нар энэ зүйл заалт гэдгээсээ илүүтэйгээр агуулгын хэрэгжилт энэ үр дүнгийн асуудлыг илүү цаашдаа тооцдог байвал яасан юм бэ гэдэг асуудал.

Тэгээд өнөөдөр бол иргэд ярьдаг юм шүү дээ. Хууль хангалттай сайн хуулиуд байгаа. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэдэг зүйл. Өнөөдөр Үндсэн хуулиар бол хуулийг хэрэгжүүлэх сурталчлан таниулах үүрэг бол Засгийн газарт байж байгаа. Тэгээд би энэ гол асуулт юу вэ гэхээр өнөөдөр энэ хэрэгжээгүй заалтууд гэж яриад байгаа. Энэ хэрэгжээгүй хууль тогтоолууд тийм гол энэ шалтгаан нь юу вэ

гэдэг асуудал. Яагаад хэрэгжээгүй юм оо гэдэг. Юу нөлөөлөв гэдэг асуудал. Энэ дээр Хэрэг эрхлэхийн дарга та бас нэг хариулт өгвөл зүгээр байна.

Дээр нь бас шинэ Засгийн газар бүрэлдээд яг энэ хууль хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах дээр бол Энхбаяр сайд бас нэлээн анхаарал хандуулж ажиллах байх гэж би харж байгаа. Яах вэ өнгөрсөн жилийнхийг бодвол хувь нэмэгдэж орж ирсэн байна. Бас тайлан үндэслэлүүд нь нэлээн үндэслэлтэй тавигдсан байна. Тэгээд Монголын хууль 3 хоног гэж нэг айтгар үг байдаг. Хэчнээн сайн хууль батлаад батлаад нөгөөдөх хууль нь хэрэгжихгүй бол амьдралд ойрхон хууль батлаад нөгөөх нь амьдрал дээрээ буухгүй бол энэ өөрөө бас өрөөсгөл асуудал болж хувираад байна гэдгийг хэлье.

Дээр нь сая Байнгын хорооны даргатай санал нэг байна. Энэ асуудал дээр энэ хариуцсан сайд нь орж ирээд энэ бусад төрийн албан хаагчдыг ажлыг нь хийлгэх хэрэгтэй. Одоо бид нар энэ гүйцэтгэл тайлан гээд миний мэдэх л энэ парламент, Байнгын хорооны танхимд энэ агентлаг харьяа байгууллагуудын энэ дарга нар чинь бүтэн өдөр ч өнжих юм. Тэгээд яаж тэнд нөгөө салбар дээр нь ажил явах вэ? Тэр салбар хариуцсан сайд байгаа бол тэр сайд нь өөрөө бүрэн дүүрэн асуултдаа хариулаад, тайлангаа тавиад, төрийн албан хаагчдыг ажлыг нь хийлгэх зайлшгүй шаардлага байгаа байх гэж бодож байна.

Тэгээд тэр гол асуултдаа хариултаа авъя.

**Д.Ганбат:** Хийх ажил байдаг юм бол. Эсвэл хийсээр байгаад ажил нь ийм байгаа юм уу? Гишүүний асуултад хэн нь хариулах юм? Сайд хариулах уу? Энхбаяр сайд хариулъя.

Үгүй яах вэ би бас янз бүрийн юм хэлж болно биз дээ энэ чинь айн?

**Б.Энхбаяр:** Байнгын хорооны гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу Улсын Их Хурал ард түмний төлөөллийн байгууллага хууль тогтоохоос гадна хуулийнхаа хэрэгжилтийг байнга хянаж гүйцэтгэх эрх мэдэл парламентдаа тайлагнадаг байх гэдэг зарчмыг хэрэгжүүлэх хүрээнд Байнгын хорооны дарга бид хамтран санаачилж энэ хуулийн өөрчлөлтийг хийсэн. Энэ хуулийн хэрэгжилтийн анхных нь одоо тайлантай бид ХЗБХ танилцаж байгаа. Яах вэ цаашид бас боловсронгуй болгох олон асуудал сая Байнгын хорооны дарга хэлчихлээ. Энд чинь бараг тавиад бүх яам агентлагийн төрийн нарийн газрын дарга ингээд холбоотой холбоогүй асуудал дээрээ бүгд суугаад байхаар яг гүйцэтгэх эрх мэдэл дээр бас ард ажил нэлээн тийм хүндрэх нөхцөл байдалтай, бүх Байнгын хороонд орж танилцуулах учраас тэрийг бас Улсын Их Хурлын удирдлагууд гишүүд маань бас ойлгож бас нэг талаас хүлээж авбал их сайн байна гэж хэлэх байна.

Хоёрдугаарт ер нь энэ яг хэрэгжээгүйтэй холбоотой шалтгаан нөхцөл ярих юм их олон л юм байна. Олон юм байна. 1 дүгээрт дээрээс нь ярих юм бол засаг төрийн тогтвортой байдал их чухал байна. Төсөв бол бид 2 жилийн хугацаанд 5 удаа тодотголоо, 5 удаа өөрчилчихсэн. Хүний нөөцийн тогтворгүй байдал их нөлөөлж байна. цахимжилтын асуудал байна. Бид бол Ерөнхий сайд өчигдөр анхны Засгийн газрын хуралдаан дээрээ үүргээ өгсөн. Засгийн газар бол дотооддоо бүх асуудлаа цахимжуулна, бичиг цаас хэрэгжүүлэхгүй. Ялангуяа Засгийн газрын хуралдаанаар ордог хэлэлцдэг асуудлууд бол цаасаар явахгүй цахимжилтаар явах

тухай маргааш Засгийн газрын хуралдаанд шийдвэр гаргах гэж байгаа. Яг энэн шиг би энэ тайлангуудыг ер нь Их Хурлын гишүүддээ цахимаар шууд байнга ер нь өгдөг байвал яасан юм гэж бодоод байгаа юм.

Нөгөө нэг удаа биш. Одоо энэ хуулиар чинь жилд 2 удаа бүх Байнгын хороогоор танилцуулахаар байгаа юм. Тэгээд 1 юм орж ирэхдээ нэг ийм зузаан цаас тараачихна. Тэгэхээр гишүүд маань үзсэн үзээгүй болчихно. Тийм учраас ер нь энэ явцын мониторингийн ажлын тайланг Их Хурлын гишүүд ч тэр ард иргэд ч тэр нээлттэй ер нь танилцах ийм бололцоотой ийм байдлаар явчихвал яасан юм бэ гэсэн ийм бодол бас сая төрж байна. Тэгвэл бас их амар юм байна. Тэгээд яг ийм гишүүд тодорхой одоо яг энэ заалт, энэ асуудал бүүр яагаад ямар шалтгаан нөхцөл юу вэ гэдэг нэлээн задаргаатай орвол тэрийгээ шууд асуугаад парламент дээрээ хэлэлцүүлэг байна уу, мэтгэлцээн байна уу тайлбар юмнуудаа өгөөд явдаг бас их үр дүнтэй юм байна гэсэн ийм бодол төрж байна. Мэдээж парламент гүйцэтгэх эрх мэдэл 2-ын хооронд нэг анхаарах асуудал байна. Тэр нь би олонтоо ярьдаг байсан энэ журмууд гаргана гэдэг хууль ер нь баталмааргүй юм байна.

Одоо өнгөрсөн 2000-2004 оны хооронд зөвхөн Засгийн газар, зөвхөн Засгийн газар гүйцэтгэх эрх мэдэл. Хууль тогтоомжид нэршил заагдаагүй 700 журам баталчихсан байна. 700 журам. Тэр 700 журмын 30 орчим хувь заалт нь зүгээр хуулийн заалтын копи паст байна. Тэгээд бид энэ төрийн албан хаагчдыг үнэхээрийн ажлын мал болгосон байна. Зүгээр цаас ингэж журам.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр гишүүн гүйцээх үү? Энхбаяр сайдын микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Тэгээд ингээд нөгөө зохиомол энэ чинь нэг бид нар шалтгаан нөхцөлүүдийг харахын тулд том зургаар нь стратегиар нь харах ёстой. Бид энэ ер нь ийм зохиомол аягүй их бүтцүүд бий болгосон. Зэрэгцээ зэрэгцээ. Сайнзориг гишүүн бид 2 өмнө нь ярьж байсан. Энэ нөгөө үндэсний зөвлөл хороод. Давхардсан бүтэц чиг үүргүүд, ажилтай айл ажилгүй. Ийм том давхардсан чиг үүргүүд чинь ажлын гүйцэтгэл үр дүн гаргах гэхээсээ ажилд садаа болдог. Тэгээд маш олон энэ яам агентлагийн хүмүүс ерөөсөө ингээд журам хийгээд суудаг болчхож. Тэгээд тайлан бас үйлдвэрлээд суугаад ерөөсөө үндсэн ажил нь ийм болчхоод байна шүү дээ.

Тийм учраас маргаашийн Засгийн газрын хурал дээр бас тодорхой шийдвэр гаргая гэсэн ийм зүйлийг ярьж байгаа. Би нөгөө эцэслэж шийдээгүй учраас кабинетын зарчмаар ажиллах ёстой учраас энэ дээр шийдвэрлэгдсэнийх нь дараа бас байр суурь илэрхийлэх нь зөв байх гэж бодож байна.

**Д.Цогтбаатар:** Баярбаатар гишүүнд микрофон өгье.

**Б.Баярбаатар:** Өнгөрсөн цаг хугацаанд тэр олон баталсан олон 100 мянган тэр журмууд бол албан тушаалтанд эрх мэдэл олгосон хүнд суртлыг бий болгосон авлигажсан ийм журмууд байгаа. Энийг бол Хэрэг эрхлэхийн сайд заавал зохицуулах ёстой. Тэр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дагуу хуулийн өөрчлөлтүүд ерөөсөө маш хангалтгүй байгаа. Энэ дээр би дахиад хэлье. Жишээлбэл Үндсэн хуульд бол Ерөнхийлөгч 1 удаа 6 жил. Ерөнхийлөгчийн 1993 оны хууль дээр бол 4 жил гээд. Ямар сайндаа Цэцийн шийдвэр гарах юм уу? Өнөөдөр цэц дээр маргаан үүсчихсэн явж байгаа.

Цаашлаад Их Хурлын тухай хууль бусад хуулиуд дээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуультайгаа зөрчилдөж байж магадгүй бас ийм заалтууд зөндөө байгаа. Энийг нэн тэргүүнд яаралтай засаарай гэдэг ийм хүсэлт байна. Тэгээд өөр зүйлгүй ээ.

**Д.Цогтбаатар:** Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

**Н.Алтанхуяг:** Надаа энэ 2 их тодорхой асуулт байгаа Энхбаяр сайд. Манай Их Хурлын Байнгын хорооны тогтоол 2024 оны 12 сарын 18-нд гарсан гэдэг чинь 2025 оны 12 сар ингээд тэгээд энэ бид нар хэрэгжилт яриад байгаа юм. Энэ дээр ийм их олон заалттай л даа. Нөгөө эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн асуудлаар бид нар Улсын Их Хурал дээр их том сонсгол явуулаад тэгээд тэрний дараа ер нь энэ болохгүй байгаа юм байна даа энийг өөрчилье гээд ингээд яриад Байнгын хорооны тогтоол гарсан байгаа. Энэ Засгийн газарт юу гэж хэлсэн юм гэхээр эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгадаг бие даасан тогтолцоо бүрдүүлж 2025 оны хаврын чуулганы хугацаанд Хууль зүйн байнгын хороонд танилцуулах гэсэн юм. Энэ танилцуулагдаагүй.

Ер нь тэгээд түрүүн хэн хэлчхэв Сайнзориг гишүүн. Одоо ингээд гэрийн даалгавраа хийгээгүй хүүхдийг яадаг юм? Харин тийм яадаг юм? Хэдүүлээ нэг ийм бүх юм нь ажилладаггүй байгууллага шиг суугаад баймааргүй байна шүү дээ. Дараа нь ийм байгаа юм. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа иргэдийг эрүүдэн шүүсэн, хүнлэг бус, хэрцгий хандсан, хүний эрхийг зөрчсөн албан тушаалтны талаарх мэдээллийн сан үүсгэх замаар үгүй ядаж энэнийх нь санг үүсгэсэн юм уу?

Албан тушаалд томилогдоход зайлшгүй харгалзаж үзэх нөхцөл байхаар төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжид хуульд өөрчлөлт оруулъя гэсэн юм байхгүй ээ. Энэ манай Байнгын хороон дээр нэг 38 иргэн яваад байгаа. Эрүү шүүлт болгоод гэмт хэргийн хохирогч болчихсон. Тэгээд тэрэнд сэтгэл зүй, эрүүл мэнд, эд хөрөнгийн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхөн төлбөр олгох талаар бас юм хийе гэсэн. Энэ маань бас байхгүй байгаа. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт өгөөдхөөч. Ер нь тэгээд байна шүү дээ энэ улс төрийн ажил би ингээд энэ төр засагт ажиллаж байхад хүсэл зориг гэж нэг юм байвал ажил явдаг юм. Хүсэл зориг байхгүй бол ер нь тэгээд л ажил явахгүй л дээ явахгүй. Тэгэхээр ийм асуудал бас нэг хариулт өгөөдхөөч. Одоо бид нар нэг баахан юм болж байгаад нэг хууль батлангуут тэр чинь хэрэгжихгүй байна шүү дээ. Энхбаяр дарга та, Энхбаяр сайд та бид нар бүгдээрээ ороод л баталсан.

Үгүй одоо нөгөө нэг хавтаст хэргийнх нь хүрээнд асуудал шийдээд цагаатгана эсвэл буцаахгүй гэсэн чинь одоо ингээд л байхгүй. Үгүй ингээд бид нар ер нь хууль батлахын хэрэг байгаа юм уу? Би бүүр тэндээ ч эргэлзэж эхэлсэн.

Хоёр дахь нь Прокурорын дэргэдэх мөрдөн бид нарын үед нэг 9 гишүүн санаачлаад алга болгоод устгачихсан. Одоо хэдэн жил ярьж байна? Би нэг жилийн тайлангийн тухай яриагүй байна. Арван хэдэн жил юу ч хийхгүй. Хийнэ ээ, хийнэ, нэг юм хийнэ. Тогтолцоо ярьж байна шүү 3 дахь нь энэ газар газар чагнаад тагнаад байдаг юмаа янзлаад нэг мөрдөн байцаах нэг юмаа нэгтгье мэгтгэе гээд энэ бол бүүр нохой долоосон юм шиг байгаа юм. Хүсэл зориг байхгүй учраас би тэгж ойлгож

байна. Энхбаяр сайд та саяхны Хууль зүйн сайд учраас бас хэлж байгаа. Тэр Хэрэг эрхлэх гэхгүй. Та нэг бас нэг зангилаан дээр оччихсон хүн байна.

**Д.Цогтбаатар:** Алтанхуяг гишүүнд нэг минут нэмж өгье.

**Н.Алтанхуяг:** Тэгээд би Сайнзориг гишүүнтэй санал нэг байгаа юм. Тэгээд л нэг ийм жижүүрийн нэг ийм үхээнц хэдүүлээ нэг хагас хугас нойрмоглосон байдалтай нэг юм яриад л. Тэгээд ямар ч ийм дайчин давшингуй арга хэмжээ авсан шийдсэн юм байхгүй. Үгүй ядаж шийдээд батлаад гаргачихсан хууль чинь хэрэгжихгүй болохоор яах юм бэ? Тэгээд энэ та нар тэр орондоо олзлолдож олзолдон булаалддаг орондоо унтах завгүй олзолдон булаалдаж хөнжилдөө орох завгүй хөндлөлдөн булаалдах ч яах вэ? Энэ ажлаа ажлаа хиймээр байна шүү дээ. Хэн ч гарч ирсэн хэнбугай нь ч гарч ирсэн юм юм нь явж байдаг. Тэгээд арван хэдэн жил ажилласангүй. Би сүүлийн 3 асуудлаас бас нэг хариулт авчихъя.

Энэ ард иргэд сонсог. Яагаад хийдэггүй юм бэ? Ийм ажлыг.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Алтанхуяг гишүүн Эрүүдэн шүүхийн эсрэг Хүний эрхийн Комиссын тайлантай холбоотойгоор мөн сонсголтой холбоотойгоор гарсан Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн талаар асууж байна. Мөн энэ хүрээнд эрүүдэн шүүх хүссэнтэй холбоотой хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан алба буюу прокурорын мөрдөн байцаах албыг буцааж байгуулахтай холбоотой заалтын талаар асууж байна.

Энийг бол миний хувьд анх энэ бие даасан Мөрдөх албыг байгуулах санал боловсруулах чиг үүргийг 2023 оны 7 сард Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга байх үедээ Засгийн газарт чиглэл болгосон тогтоол гаргаж байсан. 2023 оны 10 сард энэ асуудлаар мөн ажлын хэсэг гаргаж байсан. Би 7 сар Хууль зүйн сайдаар ажиллаад сонгууль болоод энэ ажлаа хийж дуусгаж амжаагүй. Сая 2025 оны 10 сард ХЗДХ-ийн сайдаар томилогдоод би ажлын хэсэг гаргасан. Ямар ажлын хэсэг гаргасан бэ гэхээр Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулга. Прокурорын мөрдөн шинээр байгуулах асуудал. Энэтэй холбоотой ЭХХШТХ-д өөрчлөлт оруулах ажлын хэсгийг нэлээн хязгаарлагдмал хүрээнд байгуулж хуулийн төслүүдийг бэлэн болгосон. Би. Ер нь ил тод хэлж байсан. Сая чуулганы завсарлагааны хугацаанд орон нутагт томилолтоор ажиллах үедээ прокурорын мөрдөнгийн асуудлыг би хаврын чуулганд өргөн барина гэж хэлж байсан.

Тэгэхээр хуулийн төслүүдийг бэлэн болгосон байгаа. Гэхдээ энд нэг зарчмын өөрчлөлт байгаа. Өмнөх хонгилын хаан болж байсан Дорлигжав гэж хүн прокурорын мөрдөнг бизнесийг дээрэмдэх хэрэгсэл болгож ашигласан. Дуртай хэргээ харьяаллын бус хэргүүдийг тэр мөрдөн байцаах албан дээр татаж авч хүмүүсийг хорьж цагддаг дээрэмддэг гэдэг асуудал яригдаж байсан. Тэр Тордойн Ганболд гэж нөхөр яриад байдаг биз дээ. 4 сая доллароо би дээрэмдүүлсэн гээд. Тэгээд энэ Их Хурал дээр Алтанхуяг гэж Ерөнхий сайдыг огцруулахад ахыг нь барьцаалж байгаад янз бүр болчихсон гэж ярьдаг биз дээ?

Тийм учраас буцааж мангас дахиад амилуулж болохгүй гэдэг хүрээнд нэлээн ул суурьтай бас судалгаа хийсэн. Ингээд хэргийн харьяаллын хувьд мөрдөн шалгах

үйл ажиллагааны хувьд бол их тийм онцлог байдлаар хуулийн төслийг боловсруулсан. Дурын хэргийг биш. Хууль хяналтын буюу бусад мөрдөх албадаас гүйцэтгэж байгаа гүйцэтгэх ажлын хууль тогтоомж зөрчих, эрүүдэн шүүж байгаа. Тэр хуульчийн тэр үйл ажиллагаа, хэрэг мөрдөхдөө гаргаж байгаа алдаа завхрал байна уу, авлига байна уу тэр хэргүүдийг тусдаа шалгадаг. Ийм прокурорын дэргэд бие даасан Мөрдөх алба байгуулах ийм хуулийн төслийг бол шинэ Хууль зүйн сайдын ширээн дээр байгаа гэдгийг би хэлье.

Яг цаашаа яах вэ гэдгийг Хууль зүйн сайд хариулах ёстой байх.

**Д.Цогтбаатар:** Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

**Д.Цогтбаатар:** Би 3 тодорхой асуулт асуусан шүү дээ. Тэрэн дээр хариулт өгөх хэрэгтэй. Тэгээд Прокурорын дэргэдэх мөрдөнг нь хүсэхгүй л байх шиг байгаа юм. Тэр нэг баахан дээр үеийн хүмүүсийн нэг нэр хэлдэг. Одоо тэгмээргүй байгаа юм. Арван хэдэн жил юу хийгээд байгаа юм бэ л гээд байгаа юм. Тийм учраас хэдүүлээ нэг жаахан конструктив баймаар байгаа байхгүй юу. Одоо ингээд ийм ийм алдаа дутагдал гарч байсан. Энэ алдаа дутагдлыг ингэж хуулиар хаах хэрэгтэй. Цаана чинь Солонгос улс ингээд тэр толгой дээрээс нэг нөхөр чиглэл өгөөд байхаар нь тэрнийг гүйцэтгэсэн нөхдүүдэд нь 10 жил хүртэл ял өгдөг болсон байна лээ шүү дээ. Тэр бол би тэр хуулийн байгууллагын хүнийг хамгаалж байна гэж ойлгож байгаа. Чи 10 жилийн ял эдлэх юм уу эсвэл тэр дохиурын хүүхэлдэй болж ажиллах юм уу? Үгүй ингээд энэ айлын хүүхдүүд яагаад ингээд юмаа хийгээд болоод байдаг. Манайхан юм ярихаар л нэг 10 хэдэн жилийн өмнөх сайн муу жишээнүүд аваачаад хийчихдэг юм. Бас ингэж хандаж болохгүй. Тэрнээс чинь хойш өчнөөн хүн солигдлоо шүү дээ.

Хууль зүйн яам хариулах уу? 4 дүгээр микрофон, Мягмар дарга.

**Н.Алтанхуяг:** Алтанхуяг гишүүний асуултад хариулъя аа. Таны дурдсан эрүүдэн шүүх болон хэрцгий хүнлэг бусаар доромжлон харьцсан хүнийг төрийн албанд авдаггүй байхтай холбоотой зохицуулалтыг сайжруул гэсэн. Энэ асуудлаар яах вэ ХЗДХЯ бол урьдчилсан судалгаа хийсэн төрийн албаны тухай хуульд бол төрийн албанд авах нийтлэг шаардлагад бол ял шийтгэлгүй байх гэдэг энэ зохицуулалт бол үйлчилж байгаа.

Тийм учраас бид бүхэн одоо Их Хурал дээр яваа хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой хуулийн төслүүдийг дагалдуулаад Эрүүгийн хуульд эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус хэрцгий хандах, хэрцгий доромжлон харьцах асуудлыг Эрүүгийн хуульд тусгахаар ингээд оруулаад ирж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол олон улсын гэрээ конвенцын зөвлөмжөөр өгсөн үүргийн хүрээнд ялгамжтай зохицуулж ингэж орж ирж байгаа. Хэрвээ энэ зохицуулалт маань хүчин төгөлдөр болоод ирэх юм бол хүнлэг бус хэрцгий хандсан улсууд ял шийтгэлээ авна. Эрүү шүүлт тулгах улсуудын.

**Д.Цогтбаатар:** Гүйцээгээд хариулах уу? Мягмар дарга тэгье.

**Н.Мягмар:** 4 дүгээр микрофон. Тийм. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол Засгийн газраас энэ чиглэлийн хуулийн төслөө боловсруулаад Их Хурал дээр ирүүлчихсэн байгаа гэсэн үг. Энэ маань батлагдчих юм бол энэ чиглэлээрээ хууль хүчин төгөлдөр болоод ирэхлээр ял шийтгэл аваад явчих юм бол төрийн албанд авахгүй

байх тэр тогтолцоо илүү тодорхой болно оо. Одоогийн хүчин төгөлдөр Төрийн албаны хуулиар бол ял шийтгэлгүй байх гэдэг энэ шаардлага бол явж байгаа. Тийм учраас аливаа байгууллага бол төрийн албанд авахдаа энэ лавлагаа юмыг нь авч бүртгэж байгаа учраас илүү тодорхой болно оо л гэж ингэж ойлгож байна аа.

**Д.Цогтбаатар:** Би Алтанхуяг гишүүнд нэг минут өглөө. Гэхдээ би ингэж ажиллахгүй шүү хэдүүлээ та багтааж л асуух ёстой шүү.

**Н.Алтанхуяг:** Баярлалаа. Дараа нь санал хэлж болох билүү? Болно. Үгүй тэгэхээр энэ асуултад хариулахгүй шүү дээ. Тэгээд асуусан нь бурууддаг ийм болоо. Асуулт асуухаар ирээдүй цаг дээр юм ярьж байна шүү дээ энэ чинь. Тайлан байхгүй юу. Яагаад тайлан тайлан тавих ёстой шүү дээ. Би нэг жил байтугай 10 жил хийгээгүй ажлыг чинь асуугаад байна шүү дээ. Яагаад байгаа юм бэ? Та нар яагаад хийдэггүй юм бэ? Харин би асуугаадахъя. Асуугаад биш хэлээдэхье. Ер нь энэ хууль зүйн салбар гэдэг чинь үнэхээр бас биш байна шүү дээ. Бид нар тэгэхээр энийгээ янз яаж янз янзлах вэ? Яаж хурдан янзлах вэ? Яаж зөв янзлах вэ гэж асууж байна шүү дээ. Энхбаяр сайд та тэр асуултад хариул даа. Одоо хэллээ шүү дээ. Бид нарын.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр сайдын микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Үгүй би та хэд маань Хууль зүйн сайдаас л асуугаад байгаа байхгүй юу. Тэгээд би ингээд өөр ажилд яачхаад Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогын асуудалд хариулаад байх нь их зохимжгүй байгаа юм. Энийг парламентын гишүүд та хэд маань ойлгож байгаа байх тэ? Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний зүйлийг аль болох асуух, холбогдох сайдаас нь асуувал их зүгээр байгаад байгаа байхгүй юу.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр дарга ингэе. Энхбаяр сайд энэ дээр арай өнөөдрийн яг энэ хэлэлцүүлэг дээр бол төрийн нарийнууд нь салбар салбараасаа ирэх ёстой, төрийн нарийн нь ирчихсэн байж байгаа. Сайдаас нь асуух асуулт байвал жич Алтанхуяг гишүүн бид нар энийг энэ асуулт тавигдлаа. Та нар бүртгээд ав. Энэ дээр хариултаа Алтанхуяг гишүүнд яг нэр заагаад ирвэл хувийг нь надад ирүүлээрэй за юу.

Хариултыг ингэж өгөхөөр шийдье. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Тэгээд өнөөдөр бид нарын уг нь хэлэлцэж байгаа асуудал чинь юу шүү дээ. Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан байхгүй юу. Шийдвэрийн биелэлт. Тэрнээс хуулийн хэрэгжилтийн үр дүнгийн шинжилгээ, үр нөлөөний шинжилгээ биш шүү дээ. Тэгээд энийгээ анхнаасаа Энхбаяр сайд энийгээ хэлээч. Хууль хэрэг яагаад хэрэгжихгүй байна, үр нөлөө нь яаж байна яагаад болохгүй байна гэдэг чинь тусдаа процесстой тусдаа бид нар энийг маш нарийвчилж ярьдаг. Бид нарын өнөөдөр энэ хэлэлцэж байгаа юм чинь Улсын Их Хурлын тогтоолоор байна уу? Хуулиар журам батлахаар байна уу? Энэ чиглэл шийдвэрүүд чинь яаж биелж байна гэдэг энэ тайлан биз дээ. Ингээд бүүр ингээд бүгдийг нь ингээд аваад хамаад ингээд бүгдийг нь ингээд явчихаар чинь энэ өнөөдрийн энэ тайлангийн хэлэлцүүлэг чинь ер нь жоохон утгаа алдах гээд байна шүү дээ.

Тэгээд яах вэ би энэ тайланг хараад ингэж бодлоо. Манай тамгын газраас бас дүн шинжилгээ хийсэн юм байна. Тэгээд нэлээн яах вэ ингээд тоон шинжилгээнүүд байна. Тоон шинжилгээ энэ нь тэд нь биелсэн, тэд нь биелэхгүй, бид нарт угаасаа юм өгөхгүй ээ. Гэхдээ та бүхэн яг нарийвчлан харах юм бол энэ хуулийн энэ нь яагаад биелээгүй ямар тайлбар байгаа юм, яасан гэдэг юм гэдэг нь нарийн байгаа байхгүй юу. Бид нар бүгдээрээ өөрсдөө уншчихмаар байгаа байхгүй юу. Тэгээд уншъя гэхээр яг үнэнийг хэлэхэд энэ материалыг маш тулгуу өгөхөөр энэ чинь ядаж 14 хоног бид нар байж байж нарийвчилж юмаа харж байж энэ дээр тэгвэл бодлогын ийм шийдэл гаргая гэдэг юм ярихгүй бол хурал эхлэхээс 2 өдрийн өмнө өгчихөөр чинь энэ нарийн дүн шинжилгээг нь бид нар уншиж амжихгүй байна л даа. Ингээд харах юм бол уг нь яг ингээд энэ хуулийн энэ заалт нь яагаад хэрэгжээгүй юм, энэ шийдвэр яагаад биелээгүй гэдэг чинь ийм ийм учиртай байна гээд ард нь ингээд биччихсэн байгаа юм.

Тэгэхээр энийгээ цөмөөрөө нэг хэлэлцэх энэ форматаа байдаг юм уу, нэг дэг журамд оруулахгүй бол нэг их цар хүрээг нь томруулаад л энд тэндээсээ ингээд л яваад байх 1 дүгээрт үр дүнгүй байна гэж харж байна.

Хоёрдугаарт зүгээр миний нэг их асуумаар байгаа юм бол Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 2025 онд Хууль тогтоомжийн хуулийн 6 сарын 27-нд Хууль тогтоомжийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлуулсан. Ажлын хэсгийг нь ахалж ажилласны хувьд энэ хууль дагуулаад тогтоол гаргасан юм. Энэ тогтоолоор бол 2026 оны 5 сарын 1 гэхэд энэ хуулиас давсан хуулийн эрх хэмжээг даваад баталчихсан хуулиар эрх хэмжээ өгөөгүй байхад баахан баталчихсан журам, заавар, маягтаа цуцлаа. Энийгээ бүгдийг нь цэгцэлж орж ир гэдэг энэ даалгаврыг Улсын Их Хурлаас 2026 оны 5 сарын 1 гэхэд оруулж ир ээ. Тэгэхгүй бол бидний нийгмийн харилцааг зохицуулж байгаа 400 хэдэн хууль чинь үйлчлэхгүй тэрийг давж гарсан захиргааны шийдвэрүүд буюу ард түмнээс эрх аваагүй агентлагууд яамдууд захиргааны энэ асуудлаараа журмаараа нийгмийн харилцааг зохицуулаад байна.

Ингээд гажуудаад байна гэдэг энийг бодлогын том шийдэл байсан. Энэ ч утгаараа маш том энэ даалгаврыг Засгийн газарт өгсөн байгаа.

Одоо өнөөдөр 4 сарын 7, 5 сарын 1 хүртэл гуравхан 7 хоног байна аа. Ингээд түрүү жилийн 6 сард энэ шийдвэр гарснаас хойш Засгийн газар энэ дээр хэр ажиллаж тэр олон 2008 зуугаа журмынхаа хэдийг нь цэгцэлж хэдийг нь хүчингүй болгоод хэдийг нь засчхаад байгаа юм бэ? Явцын тайлан гарсан байлгүй дээ.

**Д.Цогтбаатар:** Яах уу нэмж тодруулах уу? Хэн хариулах вэ энэ дээр? 4 дүгээр микрофон Мягмар даргын микрофоныг өгье.

**Н.Мягмар:** Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Хууль тогтоомжийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу захиргааны хэм хэмжээний акт гаргахтай холбоотой тавигдах шаардлагуудыг хүрээ хязгаар, зорилго, агуулгад нь нийцүүлсэн ийм байдлаар бол хууль тогтоомжийн төсөлд бол эрх олгосон заалтыг оруулахаар ингэж заасны дагуу өнгөрсөн оны Захиргааны ерөнхий хуулийн дагуу хэм хэмжээний актын тайлангийн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанд оруулж 2025 оны 206 дугаар тогтоол гаргасан. Энэ хүрээндээ энэ хууль тогтоомжийн хуулийн өгсөн үүрэг даалгаврын дагуу сайд нарт буюу Засгийн газрын

гишүүдэд энэ чиглэлийн өөрсдийнхөө эрхлэх асуудалд хамаарах хууль тогтоомжийн төслүүдээ нягталж түүнийгээ дагаж гаргасан хэм хэмжээний актуудаа нийцүүлэе гэдэг үүрэг өгчихсөн. Сайд нараас бол түрүүчээс нь эхлээд өөрсдийнх нь салбарын хууль тогтоомжийн хүрээнд хэм хэмжээний актынхаа агуулга зорилтуудыг үзээд хүчингүй болгохыг нь эсвэл хуульд нийцүүлэхийг нь нийцүүлэх.

Дээрээс нь хуульд тусгах энэ ажлуудаа бол хийж байгаа мэдээллүүдээ ирүүлж байгаа. Одоогийн байдлаар бол бид нар нэгтгэсэн тайланг арай гаргаж амжаагүй байна. Бид нарт ирүүлж байгаа хэм хэмжээний актын юугаар бол ажлын хэсгүүд бол ХЗДХ-ийн сайдаар ахлуулсан яамдын Төрийн нарийн бичгийн даргаар гишүүд нь бүрдсэн ийм ажлын хэсгийн хүрээнд бол 2 удаагийн уулзалтаа хийж явсан энэ чиглэлийг эрчимжүүлэх үүргийг өгчихсөн. Ингээд явж байгаа.

**Д.Цогтбаатар:** Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

**О.Номинчимэг:** Бүтэн нэг жил болж байна аа. Тэгээд тайлан нь ирээгүй үр дүн нь ямар байгааг мэдэхгүй гээд сууж байх бас зохимжгүй байна. Энэ чинь энэ хууль тогтоомжийн хууль дагаж гарсан хамгийн том бодлогын асуудал. Одоо Засгийн газрын тэргүүн маань чөлөөлье гэдэг аян хэрэгжинэ. Энэ хууль дүрэм журмаараа бараг боодог биш. Хууль гаргах биш хуулиа хүчингүй болгож бараг чөлөөлж байж энэ нийгмийн амьдрал чинь явах нь гэдэг шийдэлд бид нар угаасаа хүрчхээд байгаа шүү дээ. Нэг л бүгдээрээ мэддэг болоод л баахан хууль дүрэм гаргадаг тэр нь бүх юмны гацаа түгжээ болоод байдаг. Тэгээд энэ 2008 зуугаад энэ журмыг чинь хэдэн зөрчилтэй байгаад хэдийгээ яг өөрчлөх тийм үү? Өөрчлөх юмнууд байгаа, заримыг нь хүчингүй болгох юмнууд байгаа. Тэр чинь өдийд тодорхой болчихсон байх хэрэгтэй шүү дээ. Тэгээд энэ дээр Хууль зүйн байнгын хорооны даргадаа хэлэхэд 5 сарын 1-ний дараа шууд энэ хууль тогтоомжийн энэ хуулийн тогтоолын хэрэгжилтийг шууд Байнгын хороон дээрээ сууж байж шахах цаг болжээ. Тэгэхгүй бол ингээд л хэрэгжихгүй байгаа. 2, 3 жилийн дараа хэрэгжээгүй гэсэн юмтай бид нар сууж байж болохгүй байна гэдгийг хэлмээр байна.

**Д.Цогтбаатар:** Нэмж хариулах уу? 4. Хэрэггүй хэрэггүй тэгвэл. Ойлголоо Номинчимэг гишүүн ээ. Саяын яг 5 сарын 1-нд хэдүүлээ энэ хийх таны ажлын талаарх саналыг би сая ойлгож хүлээж авлаа. Хэдүүлээ суугаад энэ дээр чинь тэгвэл ажлаа тэгээд таны саналыг чинь боловсруулаад бид нар тэгвэл холбогдох байгууллагууд руу нь саналаа тавиад явъя тэгэх үү, нэг.

Хоёрт ийм юу байна шүү. Номинчимэг гишүүнээ та ингээд 2 хоногийн өмнө өгсөн гээд тэгэхлээр энэ бичиг өөрөө 18-нд ирсэн. 3 сарын 18-нд. Манай Байнгын хороон дээр 23-нд ирээд бид нар 24-нд бүх гишүүдэд тараасан байгаа шүү 3 сарын. Та тэгэхээр өөрийнхөө бас ажлын алба хүмүүстэйгээ юу яагаарай. Би яг энд сая нягтлаад хараад сууж байгаа юм. Түүнээс 3 хоногийн өмнө ирсэн биш шүү. Манай л лав Байнгын хорооны зүгээс. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

**О.Номинчимэг:** Яах вэ миний хэлэх гээд байсан санаа нь тэгвэл 7 хоног ч юм уу арваад хоногийн өмнө ирсэн юм байна. Гэхдээ бид нар хяналт шалгалтын хуулийн дагуу өнөөдөр юу хэлэлцэх гээд байгаа юм. Тэгээд цар хүрээгээ тодорхойлохгүй бол тэгээд энэ дээр агуулга дээр нь юм биччихсэн байхад энийгээ ярихгүй асуудлынхаа шал өөр юмаар л яваад байна гэж байгаа юм. Тэгэхээр гишүүд маань юмаа уншаагүй л байгаа байхгүй юу. Зарим нь уншаагүй байх. Яалт ч үгүй засаг төр энэ чинь бужигнаад ийшээгээ анхаарах завгүй л боллоо шүү дээ. Тэгээд

хаа хаанаа энийгээ яахгүй бол ингээд нэг бүүр ингээд хэлэлцүүлэг чинь задгайраад цар хүрээнээсээ даваад байна л гэсэн асуудал байна.

**Д.Цогтбаатар:** Зөв зөв. Миний зүгээс бол гишүүд асуудлаа уншаад л танилцах ёстой. Гэхдээ гишүүн юу асуухыг Байнгын хороон дарга мэдэж би микрофоныг нь хааж чадахгүй шүү. Тэгээд гишүүд өөрсдөө хариуцлагатайгаар юмаа уншаад асуух юмаа хүрээндээ асуух ёстой. Ингээд Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

**Х.Баасанжаргал:** Би нэг агуулгаас гадна яг энэ процесстой холбоотой яг энэ тайлантай холбоотой нэг зүйлийг Их Хурлын хяналт шалгалтынхнаас асуугаадахъя. Одоо яг энэ нөгөө Номинчимэг гишүүний болоод өөр бусад гишүүдийн асуулт дээр 2 том ийм байр суурийн зөрөө байгаад байна л даа. Бид нар яг юу сонсох юм бэ? Яг жишээ нь Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд 2 заалт түүж орж ирээд тэр 2 заалтын нэг нь хэрэгжсэн, нэг нь хэрэгжээгүй. Харахаар энэ 2 нь хоёулаа журам батлах байгаа байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр Байнгын хороо журам баталсан уу батлаагүй юу гэдгийг хэлэлцэх юм уу? Эсвэл тэр журам баталснаараа хэрхэн хэрэгжиж байгааг хэлэлцэх юм уу. Энэ 2-ын ялгааг гаргаж ирэхгүй бол хэрвээ бид нар журам баталсныг зөвхөн хэлэлцэнэ гэх юм бол тэгээд л 10 журам батлах ёстой арвуулаа батлагдсан байна. Тэгвэл яг энэ хуулийн заалтын цаад үзэл санаа нь юу юм? Яах гэж ийм Хяналт шалгалтын тухай хуулиар Байнгын хороо энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг сонсож байгаа юм бэ гэдэг дээр нь би одоо бүр сүүлдээ эргэлзэж эхэлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ хоёрынхоо ялгааг гаргаад одоо бид нар энэ тайланг 3 дахь удаа сонсож байгаа гэж ойлголоо. Зөв тэ? Анхны удаа биш. Тэгэхээр энэ уг нь бол аягүй чухал механизм байхгүй юу. Их Хурлын баталсан хууль тогтоомж чинь хэр хэрэгжиж байна вэ гэдгийг бид нар байнгын тогтмол сонсдог ийм чухал механизм гэж хармаар байгаа юм. Тэрнээс биш зүгээр нэг юм сонсоод өнгөрдөг ажил болгоод энэ манай энэ парламент энийгээ аягүй зөв жишигтэй болгомоор байгаа байхгүй юу. Тэгэхээр яг энэ заалт яах гэж энэ тайланг бид нар сонсож байгаа юм бэ гэдгийг 1 дүгээр асуулт гэсэн үг.

Хоёрдугаар асуулт юу вэ гэвэл дахиад яг үүнтэй холбоотой гарч байгаа. Яг энэ хууль тогтоомж хэрэгжсэнээрээ энэ дүрэм журмыг баталснаараа жишээ нь Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг 2013 онд баталжээ. Тэрнээс биш 2 журмын нэгийг нь одоо болтол батлаагүй явж байгаа юм байна аа. Энэ батлагдах юм бол гэрч хохирогч бүрэн дүүрэн хамгаалагдах юм уу эсвэл өөр асуудал байгаа юм уу? Бүтцийн асуудал байгаа юм уу? Төсвийн асуудал байгаа юм уу? Зөвхөн журам нь батлагдсанаараа болох гээд байгаа юм уу? Яг хэчнээн гэрчийн эрх ашгийг бид нар хамгаалж чадах юм бэ? Үүнээс болоод юу нь болохгүй байгаа юм бэ? Хэнийг хамгаалж чадахгүй байгаа юм бэ? Яг энэ хууль хүний амьдралд ямар өөрчлөлт гараад байгаа юм бэ гэдгийг л сонсмоор байна гэсэн үг. Тэгэхээр ийшээгээ чиглүүлээд 2 дахь асуулт юу вэ гэвэл Их Хурлын болоод Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм журмаа энэ тайлан сонсдог энэ тайланг ирүүлдэг энэ дүрэм, журмаа өөрчлөөд нэг жоохон ийм үр дүн рүү чиглүүлэх боломж бололцоо байна уу? 4 дэхээ дахиж бид нар ийм тайлан сонсмооргүй байна гэсэн үг.

Гурав дахь асуулт юу вэ гэвэл хуулиудаас гадна дахиад энэ хүний эрх, эрх чөлөөний баталгаатай холбоотой ХЭҮК-оос гардаг жил болгоны тайлангийн хэрэгжилтийн үнэлгээ сая ирлээ. 50 хувь нь дахиад байхгүй. Хэрэгжих шатдаа

нийтдээ 20 заалт байгаа юм байна 7 заалт нь хэрэгжсэн, 10 заалт нь хэрэгжих шатдаа буюу 50 хувь. 2 заалт нь огт хэр хэрэгжих боломжгүй гээд сүүлийн 5 жил бид нарын баталсан энэ хүний эрх эрх чөлөөтэй холбоотой тайлан илтгэлийг сонсоод 20 заалтаар үүрэг болгожээ.

Тэгээд энэ яг зөв үү гэдэг дээр би жаахан эргэлзээд байна. Тэгэхээр энэ яг зөв үү? Тэгэхээр бид нар хаана энэ цикл дээр хаана ямар алдаа байна вэ гээд.

**Д.Цогтбаатар:** Хэн хариулах вэ? Эрдэнэбат даргын 8 дугаар микрофон.

**Г.Эрдэнэбат:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр үнэхээр улс Засгийн газрын болон Улсын Их Хуралд ажлаа хариуцсан тайлагнадаг байгууллагуудын тайланг хэлэлцэх явцад бол Улсын Их Хурлын гишүүд удаа дараа тайлан боловсруулахдаа зөвхөн зохион байгуулалтын чанартай болон бэлтгэл ажлын шинжтэй үйл явцыг тайлагнаад байна аа. Хууль тогтоомжид тусгасан гол үр дүнгээ тусгахгүй байна гэдэг энэ асуудлыг удаа дараа хэлж байгаа. Тэгээд яах вэ Улсын Их Хурлын Тамгын газрын энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх газраас бол нэг зовлон байгаа нь тайлан ирүүлсэн тайланд нь бид нар дүн шинжилгээ хийх ёстой.

Тэгэхээр тэнд яригдаагүй асуудлыг тийм байна ийм байна гэж ярихад их төвөгтэй. Тайлан дээр нь байгаа зүйл нь үнэн бодитой байна уу гэдгийг бол бид нар дүн шинжилгээ хийгээд өгч байгаа. Цаашид бол яг таны хэлсний дагуу бид нар энэ тайланг дүгнэх журамдаа мэдээж өөрчлөлт оруулах ёстой, сайжруулах ёстой мөн тайлагнах журам Засгийн газрын зүгээс харьяа байгууллагуудын зүгээс тайлагнах журам, төлөвлөх журам хоёроо сайжруулахгүй бол үр дүн рүү чиглэсэн төлөвлөлт хийгээд ингээд түүнийхээ араас тэр төлөвлөлт нь үр дүндээ хүрсэн үү үгүй юу гэдгийг тайлагнадаг ийм журам руу шилжих шаардлагатай байгаа. Энэ гарцаа байхгүй хийх ёстой ажил. Улсын Их Хурал дээр энэ тайлангууд ирээд нэг ойролцоогоор 10-аас 15 хоногт дүн шинжилгээ хийгдэж байгаа юм. Энэ хооронд цаана нь болсон үйл явдлыг бүхэлд нь татаж авч үзээд ерөөсөө тэр төлөвлөлт нь буруу байсан уу зөв байсан уу. Тэгээд ерөөсөө ямар асуудлыг голлож яриад ямар үр дүнгийн тухай өгүүлэх ёстой байсан бэ гэдгийг Тамгын газрын зүгээс бол татаж аваад ингээд ярих бол бас жоохон бодит бололцоо байхгүй байгаад байгаа.

Энэ дээр бол үнэхээр харамсалтай байгаа. Таны хэлсэн жишээлбэл журам батлахтай холбоотой мөн түүнийг дагаад дэг зөвлөл байгуулахтай холбоотой гэх мэт үүргүүд Засгийн газарт угаасаа хуулиар даалгачихсан үүрэг. Энийг Засгийн газар зөвлөл байгуулсан журам баталсан гэх нь энэ хуулиа хэрэгжүүлж байгаа хэрэг. Харин цаашдаа ингээд журам батлаад зөвлөл байгуулаад хуулиа хэрэгжүүлснээр ямар үр дүн гарав гэдгийг одоо бид нар цааш цаашдаа харилцан ярилцаад тийм тайландаа тусгадаг талаараа л ярих ёстой байх гэж ингэж бодож байгаа.

Тэгэхээр бол энэ тайлангийн ажил үр дүнтэй болох байх аа. Зүгээр өмнөх жилийн тайлан энэ жилийн тайланг харьцуулах юм бол үнэхээр Засгийн газрын ажилд бол ахиц гарсан гэж үзэж байгаа. Өмнөх жилийн Засгийн газрын тайлан дээр 20 хувьтай байсан ажил ажил жишээлбэл ижил төрлийн ажил энэ жил бол 50 гаруй хувьтай болоод ороод ирж байгаа нь үнэхээр энэ тайлан дээр дурдсан ажил хийгдсэн байна уу гээд үзэхээр ажил хийгдсэн байгаа. Зарим угаасаа нийгмийн том өөрчлөлтийн шинжтэй ажлын үр дүн угаасаа 1, 2 жилийн дотор гарахгүй л дээ.

Тэгэхээр мэдээж хэрэг зорилгодоо хүрэхийн тулд тэр шаардлагатай хуульд нийцүүлсэн журам батал гэдгийг хуулиар үүрэг болгочихсон юм чинь тэр журмаа баталж л таарна. Тэрний үр дүнг харин хэмждэгийг тайландаа оруулахыг бол бид нар дараа дараагийнхаа удаад тусгаад явахад болно байх гэж бодож байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын энэ хууль тогтоомжийн үнэлгээний 3 журмыг Улсын Их Хурлын даргад шинэчлээд батлахаар бид нар батлуулахаар бид нар өгчихсөн байж байгаа. Тэр журмууд бол ойролцоогоор нэг ойрын 2-оос 3 долоо хоногт батлагдаад тэгээд энэ журмыг хүргүүлээд ингээд бид нар Засгийн газар болон бусад байгууллагатайгаа хамтарч ажиллахад үр дүн гарах байх гэж найдаж байгаа.

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофон.

**Ч.Бат-Эрдэнэ:** ЗГХЭГ-ын ХШУДАГ-ын дарга Бат-Эрдэнэ байна. Баасанжаргал гишүүний асуултад хариулъя аа. Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т үүрэг чиглэл өгсөн тогтоолын биелэлтийн тайланг хэлэлцэнэ гэдэг ийм хуулийн зохицуулалттай. Яг одоо өнөөдөр бол Засгийн газрын түвшинд хуучин 206, Засгийн газрын 2025 оны 43, мөн 2025 оны 183 гээд тогтоолууд гарч байгаа юм. Энэ дээр нийтдээ нэг 9-өөс 10 төрлийн шийдвэр байгаа юм. Их Хурлын түвшинд гарч байгаа хууль, Их хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын түвшинд гарч байгаа шийдвэрүүд. Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгавар, Ерөнхий сайдын захирамж гээд. ҮАБЗ-ийн зөвлөмж, Ерөнхийлөгчийн зарлиг гээд энэ 9-өөс 10 төрлийн энэ шийдвэр тус бүр дээр цаашид бидэнд энэ гишүүний ярьж байгаатай адилхан үр дүн.

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофоныг гүйцээгээд өгье.

**Ч.Бат-Эрдэнэ:** Үр дүнгийн асуудлыг тайлагнах уу эс үгүй бол яг энэ өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийнхаа хүрээнд энэ журмаа баталсан гээд ингээд үйл ажиллагааг тайлагнаад явах уу гэдэг энэ асуудал гарч ирж байгаа. Тэгээд цаашид бид нар дээр ЗГХЭГ-ын түвшинд энд бие даасан хууль гарах ёстой юм байна гэж үзэж байгаа. Үе үеийн засгийн газрууд үе үеийн энэ мониторингийн нэгжүүд дээр бол энэ журмаа хэдэн янзаар өөрчлөөд 1996 оноос хойш өнөөдрийг хүрчихсэн явж байгаа.

Тэгэхээр энэ цаашдаа бол бид нар энэ хяналт шинжилгээ үнэлгээний ийм хуультай байхгүй бол 1996 оны тогтоол дээр бүх агентлаг, яам, Засгийн газар дээр энэ хяналт шинжилгээ үнэлгээний нэгжтэй байсан. Тэгээд энэ нэгжүүд маань бол зарим үедээ татан буугддаг, зарим үедээ шинээр бүтцийн өөрчлөлтөөрөө нэмэгддэг ийм асуудлууд байгаа юм. Тэгэхээр яг энэ дээр нэгдсэн ийм арга зүйгээ бид нар цаашдаа боловсронгуй болгоод яг энэ гарч байгаа шийдвэр болгон дээр энэ үнэлдэг энэ арга зүйгээ бас шинэчлэх сайжруулах ийм шаардлага гарч байгаа.

**Д.Цогтбаатар:** Энэ дээр Баасанжаргал гишүүн тодруулъя.

**Х.Баасанжаргал:** Би бүүр яг ноднин яг энийг яриад яг ийм хариулт сонсож байснаа бүүр аягүй тод санаж байна. Энэ бараг нөгөө нэг зүүдэлсэн зүүдээ буцааж үйл явдал юу билээ л гэж бодох гээд байна. Хэдүүлээ яаж цаашаа ахих вэ? Яг ингээд л байрандаа ингээд л хий эргээд л тэгээд л нэг юм ярихаар тийм ч юм

хэрэгтэй, тийм ч бүтэц хэрэгтэй гээд л ингээд л яваад байх юм уу яах юм? Ядаж Их Хурал одоо жишээ нь эндээс ирж байгаа тайланг гишүүдийн тавьсан шаардлага өнгөрсөн жил ийм юм тавьсан байна. Энэ жил энэ шаардлагыг хангаагүй бол тайланг нь авахгүй ч гэдэг юм уу ингээд нэг ийм одоогийн байгаа хууль тогтоомжийнхоо хүрээнд эсвэл энийгээ нэг жоохон маневртай болгоод ингээд нэг илүү нэг жоохон тодорхой болгочих боломж байхгүй юу л гэж асуух гээд байгаа юм.

Яах вэ 2 дугаарт доторх агуулгаас нь хэд хэдэн асуух юм байгаа. Гэхдээ яах вэ энэ удаадаа больё. Яагаад гэвэл асуугаад ч ямар ч нөгөө үр дүн гарахгүй байгаа учраас цагаа хий дэмий үрэх гээд байгаа учраас гэсэн үг шүү дээ тиймээ. Ганц анхаарал татаж байгаа бас яах вэ нэг зүйл энэ Эрдэнэт үйлдвэртэй холбоотой хэрэгжих боломжгүй нэг заалт гэдгийг нэг тайлбарлаж өгөөч. Ямар заалт хэрэгжих боломжгүй заалт орчхоод байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Эрдэнэт үйлдвэртэй холбоотой тэр асуултад хэн хариулах вэ? Уул уурхай аж үйлдвэрийн яамнаас хүн байна уу? Хэддүгээр микрофон байна. Тэр 5 дугаар микрофон дээр очоод суучих.

Холбогдох яамны Төрийн нарийн нь байна уу? Үгүй тэр төрийн нарийн та яагаад тэгээд нээрээ энэ зөв шүү дээ гишүүд. Дашпүрэв дарга хариулах уу? 2 дугаар микрофон.

**Б.Дашпүрэв:** Гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Төрийн нарийн бичгийн дарга. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэж зэс боловсруулах үйлдвэр барих төслийн асуудал байгаа. Энэ бол Монгол Улсын ЗГХЭГ, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа. Төслийн үе шат бол стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах ажил хийгдээд шорт лист нь үүсгэгчхсэн явж байгаа.

**Д.Цогтбаатар:** Нөгөө нэг журмыг хэрэгжүүлэх боломжгүй байна гэсэн хариулт ирүүлсэн байна гээд байна шүү дээ. Баасанжаргал гишүүн өөрөө уншаад тодруулаад өгчих.

**Х.Баасанжаргал:** Энэ тайлангийн 30 дугаар хуудсан дээр байна. Эрдэнэт үйлдвэртэй холбоотой авах арга хэмжээний тухай гээд. Хөгжлийн банк болон Монголбанкнаас ХХБ-нд байршуулсан мөнгөн хөрөнгө, ноогдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тогтоох хэлцэл хийж төрийн өмчид авах арга хэмжээг зохион байгуулахыг Их Хурал, Засгийн газарт даалгасугай 49 хувийн хувьцаа гээд. Тэгээд энэ дээрээ хойно нь дүн шинжилгээ хийхдээ хэрэгжих боломжгүй гэж үзлээ гээд ингээд дүгнэлт хийчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд энэ яг яагаад хэрэгжих боломжгүй гээд байгаа юм бэ энэ чинь бөөн асуудал өрнөөд байсан. Энэний чинь цаана энэ нөгөө төрийн өмчид авах гээд энэ асуудал чинь болоогүй юм уу? Болчхоогүй юм уу ямар учиртай юм гэж асуугаад байна. Энэ 30 дугаар хуудсандаа байна. Та хэд нэг хараадах даа тийм. Эрдэнэт үйлдвэрт компани болон Монголросцветметын талаар авах арга хэмжээний тухай гээд хүснэгт 9 дээр байна.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр сайд хариулъя. Энхбаяр сайдын микрофоныг.

**Б.Энхбаяр:** Энэ нөгөө Эрдэнэтийн 49-ийг төрд буцааж авах тухай Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг яриад байгаа юм. Яг энүүгээр Баасанжаргал гишүүн ийм асуудал үүсчихсэн байгаа. ҮХЦ болохоор Их Хурлын энэ тогтоол Үндсэн

хууль зөрчөөгүй. Тэгэхдээ нөхөн олговрыг нь өгч байж аваарай гэдэг шийдвэр гаргасан. Монгол Улсын Дээд шүүх уул нь нэг шүү дээ. Дээд шүүх гэж нэг институт байгаа. Дээд шүүхийн шийдвэр бол эцсийн шийдвэр. Дээд шүүхийн Иргэний хэргийн танхим болон Захиргааны хэргийн танхимын 2 эцсийн шийдвэр 2 зөрөөтэй гарчихсан байгаа. Алийг нь Монгол Улсын Дээд шүүхийн шийдвэр гэж үзэх вэ? Тэр шийдвэр нь ҮХЦ-ийн шийдвэртэй бас зөрчихсөн байгаа.

Улсын Их Хурлын тогтоол ингээд 3 эцсийн шийдвэр мөргөлддөг.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр сайдын микрофоныг гүйцээгээд өгье.

**Б.Энхбаяр:** Тийм, ийм л асуудалд орчхоод байгаа юм. Цэцийн шийдвэр нь том уу, Их Хурлын шийдвэр нь том уу, Дээд шүүхийн шийдвэр нь том уу гэхээр гурвуулаа бие биеэсээ томорч гарч чадахгүй 3 шийдвэр хоорондоо зөрөөд зогсчихоор энийг давж тайлбарлах ч хүн Монголд байхгүй. Энийг аль нэгийг нь хэрэгжүүлсэн ч аль нэг нь буруутна. Ерөөсөө ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа. Энийг бол Улсын Их Хурлын тухайн үеийн Улсын Их Хурлын бүүр тухай үеийн энэ шийдвэрийг боловсруулж хэлэлцсэн ажлын хэсгийн хаалттай хуралдаан дээр хүртэл яригдаж байсан юм байна лээ анх боловсруулахдаа. Энэ алдаатай Их Хурлын шийдвэр болох гээд байгаа юм байна шүү дээ. Жишээлбэл хүний хөрөнгийг авбал яах вэ? Онц болон дайны байдлын үед авна, дайчлан авна. Эсвэл шүүхийн шийдвэрээр хурааж авна. Ийм 2 Үндсэн хуулийн заалттай байхад нөхөн олговор олгохгүйгээр шууд авчихаар болох уу?

**Д.Цогтбаатар:** Энийг ойлголоо, тэгэхдээ ингэе. Шийдэлгүй гээд одоо өөрийн чинь ярьж байгаагаар яг цэвэр эрх зүйн үүднээс яах ч боломжгүй байна шүү дээ. Гэхдээ ингэж байж болохгүй энэ дээр бол би зүгээр Засгийн газрыг юу гэж бодож байна гэхээр Энхбаяр сайд та өөрөө бас хуульч хүн байна ахиад та нар сууцгаа. Тэгээд Их Хурлаар тусгайлан хууль гаргая. Яг тусгайлан асуудлаар тэгвэл хууль гарах шаардлага гарах уу? Тогтоол гарах уу? Энэ юмнуудаа нэг бодож эргээд санал өгөхгүй бол энэ асуулт эргээд л гар гараад байна шүү дээ.

Дараагийн тайлан дээр чинь яг энэ байдлаараа орж ирэх юм байна. Дараагийн тайлан дээр ингэж орж ирээд ахиад асуудал гарч ирэх юм байна. Энэ ингээд шийдэлгүй үлдээд байж болохгүй болохоор та хэд маань энийгээ дахиад нэг бодож үз ээ. Одоо би энд бол ямар нэгэн юм шууд зөвлөх ямар ч боломжгүй байна шүү дээ. Тэгэхээр миний зүгээс юу яаж байна гэхээр ёстой ер нь манай Байнгын хорооны гишүүдээс ч гэсэн хүмүүс оруулж байгаад наадхыг чинь шийдлийг нь хайсан нь тэгвэл та нар ажлын хэсэг байгуулах уу яах вэ? Бас нэг суугаад үзэх хэрэгтэй. Тэгэхгүй бол энийг ингээд орхиж бас болохгүй асуудал байна шүү дээ. Асуусаар л байх болно. Тэгвэл энийг ингэж тохиръё. Түүнээс энэ дээр шийдэл байхгүй байна.

Тэгэхдээ. Энхбаяр гишүүн ээ нэг ийм асуудал байгаа шүү.

Тэгэхээр байна шүү дээ Энхбаяр гишүүн ээ. Энхбаяр гишүүн наана чинь яг шүүх байгууллагаар яваад шийтгэх нь дуусчихсан байна шүү дээ. Хэзээ ч дуусдаггүй байгууллага Их Хурал байхгүй юу. Одоо наад дээр чинь тэгвэл эргээд гишүүд ч асуусаар байхаар юм байна. Тогтоол гаргах юм уу тусгайлсан хууль гаргах уу яах вэ? Энэ юмнуудаа бас тэгвэл 1 бодоод үзээч. Түүнээс би бас шийдлийг нь мэдэхгүй байна яг үнэнийг хэлэхэд.

Гэхдээ би танд нэг юмыг одоо энэ дээр би протоколд ороосой гэж бодож байна. Наад энэ дээр хэрэгжүүлэх боломжгүй гэж байгаа чинь хүн харин ёстой гомдлоо гаргаад явах Засгийн газар болон төрийн эсрэг төр буруу юм хийжээ гэсэн нотлох баримт болох юм явж байна шүү дээ. Төр өөрөө шийдвэрээ гаргаж чадахгүй, төрийн эсрэг наадах чинь нотлох баримт болохуйц юм яваад байна шүү дээ.

Тэгэхээр энийгээ бодож үзэж Их Хурал дээр ямар шийдэлд орох уу? Би үнэхээр хариулж мэдэхгүй үгүй байна. Яагаад гэвэл энэ дээрээ яг бүгдээрээ сууж байж нэг шийдэл гаргах хэрэгтэй. Бид нар бол Байнгын хорооноосоо хүн амьтан гаргаж өгч болно. Тэр саналаа л хэл л дээ. Танайх одоо жишээлбэл ингэх хэрэгтэй гэвэл би Байнгын хорооноосоо ажлын хэсэг гаргаад суух гээд үзэж болно. Тэрэн дээр надаа асуудал алга. Тэгэхэд Засгийн газар энэ байр сууриа л яагаад гэвэл танайх тайлангаа оруулж ирж танилцаж байна шүү дээ. Тэгээд энэ чинь цаашдаа ч асуусаар байх юм байна. Харин түрүүн энэ юу Баасанжаргал гишүүний юун дээр нэг юм би хэлчихмээр байна. Та түрүүн ингээд асуугаад байна шүү дээ. Энэ тайлан гэдэг дээр хийсэн ажлын тайлан гэхлээр журам хийчхээд ингээд болчихсон уу гээд.

Энэ юу хяналт шалгалтын тухай хууль дээр чинь ерөнхий утгатайгаа байж байгаа байхгүй юу. Тийм учраас зөвхөн журам гаргасан гээд зогсохгүй энэ биелэлтийн бид нар хэлэлцэнэ гэдэг чинь би ч гэсэн гишүүдийн асуултыг хязгаарлахгүй байгаа чинь энэ байхгүй юу. Яагаад гэвэл асуухдаа зөвхөн журам асуугаад зогсохгүй би түрүүн хэлсэн шүү дээ. Би бас гишүүдийг юу асуухыг хязгаарлаж чадахгүй шүү гэж байгаа чинь та нар энэнтэй хэрэгжилттэй холбоотой бүх юмаа асуух хэрэгтэй. Тэр боломж чинь нээлттэй. Энэ дээр бол харин ер нь нөгөө ямар нэгэн тогтоол шийдвэр гардаггүй сонсоод өнгөрч байгаа учраас энэ дээр гишүүдийн хэлж байгааг ёстой тэмдэглэж авна манай Байнгын хороо гишүүдийн энэ хэлсэн хэлсэн асуудлуудаар ажлаа хийгээрэй гээд хойноос нь нөхөж бид нар бич бичиг явуулах ёстой юм байна бусад байгууллагууд руу. Энийг бид нар ингэж гүйцэлдүүлж хийе гэж бодож байна.

Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

**С.Одонтуяа:** Дээд хүн суудлаа олохгүй бол доод хүн гүйдлээ олохгүй гэж. Энэ төрийн байгууллагыг чинь зүгээр нээрээ самрахыг үзүүлж өгч байгаа шүү дээ. Нэг төсөв баталчихна. Хүмүүс энэндээ тааруулаад бүх хөтөлбөр бүх юмаа хэрэгжүүлэх гээд явж байтал дахиад л төсвийг нь хураагаад авчихна. Тодотгол хийж байна гээд. Тэгээд бүтцийн өөрчлөлт хийж байна гээд баахан хүмүүсийг нь өөрчилнө. Ингээд энэ бол ер нь тэгээд бүтэхгүй л талдаа байгаа.

Би эхлээд асуултаа асуучихъя. Ер нь сая бас Их Хурлын Тамгын газрынхан хэллээ шүү дээ. Ер нь бид нар энэ үр дүнгээр нь жоохон хэлэлцдэг болъё оо гээд. Тэгэхээр ялангуяа энэ асуудал дээр Хууль зүйн яаман дээр гарч байна шүү дээ. Энэ олон улсын индексүүддээ бид нар яаж хүрсэн юм бэ? Жишээлэхэд Хууль зүйн яам яаж хүрсэн юм? Байгаль орчны яам яаж хүрсэн юм? Энэ олон улсын хэмждэг индексүүд чинь байгаа шүү дээ. Агаарын бохирдол, хөрсний бохирдол. Энэ янз бүрийн асуудал дээр. Тэгэхээр би нэг 3 тоо асуух гэсэн юм Энхбаяр дарга аа.

Нэгдүгээрт өмнө НҮБ-ынхан ирээд шүгэл үлээгээд Монгол Улс чинь шүүхийн шийдвэргүй баривчилгаа 99 хувь байдаг юм байна гээд. Бид нар ярьж байгаад энийг хуульд оруулаад батлуулсан. Тэгэхээр энэ зүйл чинь одоо яг хэрэгжээд явж байгаа

хэвээрээ юу? Ингэснээрээ бид нар энэ олон улсын конвенцод хүлээсэн үүрэг чинь ахисан уу? Хүний эрхийн индексээрээ бид нар ахиж чадсан уу? Дээрээс нь тэр хугацаагүй цагдан хорих асуудлыг бас бид нар хуульчилж өгсөн.

Тэгэхээр энэ асуудлууд чинь хэвээрээ яг зөв хэрэгжиж чадаж байгаа юу эсвэл бас энэ дээр асуудлууд байна уу? Тэгэхээр энэ 2 чухал зүйлийг бид нар хуульчилчихсан. Тэгэхээр энэ хүний эрх дээр индекс нь би зүгээр ахисан байх ёстой л гэж бодоод байна л даа. Та бас ажлаа авангуутаа олон улсын гэрээ конвенцод манай энэ Монгол Улсын хууль хэр нийцэж байгааг би нэг бүрчлэн шалгана гэсэн. Энийгээ хийсэн үү, энэний үр дүн гарсан уу гэдгийг асууя. Ер нь бол энэ би Бямбацогт даргад бичиж өгье гэж бодож байна л даа.

Манай ХЗБХ ч гэсэн энэ дээр ажиллах ёстой, ЗГХЭГ ажиллах ёстой. Энэ юу вэ гэхээр энэ шаардлагагүй энэ баахан дарга нараа л дууддагаа больчихмоор байна. Энэ хүмүүс чинь ингээд манай Байгаль орчны яамных гэхэд энд 10 хүн сууж байгаа байхгүй юу. Гол 10 хүн. Үгүй ээ харин тийм ямар ч шаардлага байхгүй. Тэгээд ирэхгүй бол загнадаг чи хэн бэ? Чи тэгвэл ажлаас чинь хална шүү гээд ингээд Хэрэг эрхлэхээс дарамталдаг энэ хүмүүс ирдэг. Тэгэхээр энийг та болиулах хэрэгтэй. Би энэчээ Засгийн газраа бас эмээдэг байхгүй юу. Тэгэхээр энэ Их Хурал дээр би бас тэр Бямбацогт даргад бичиг өгье. Ингээд дарамталдаг, энэ хүмүүс ирдэг. Очоод иргэд нь гадаа нь хүлээгээд байдаг байхгүй юу. Тэгэхээр дандаа л дарга сайд тийшээ ажилтай ажилтай гээд ингээд. Одоо нэг жоохон арга барилыг.

**Д.Цогтбаатар:** Энхбаяр сайд хариулах уу.

**Д.Цогтбаатар:** Яах вэ би Одонтуяа гишүүний асуултад 3 асуулт бол яах вэ гурвуулаа Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний юм бас асуугаад байгаа юм.

Тэгээд би ингээд Хууль зүйн сайдын ажлаа хийж байгаа юм шигээр ингээд л хариулаад байхаар энэ нэг тийм гишүүд маань бас энийг нэг ойлгож хүлээж аваач гэж би бас хэлэх гээд байгаа юм л даа. Өөр сайдын эрхлэх асуудлын өмнөөс нь ингээд хариулаад байхаар чинь их зохимжгүй шүү дээ энэ чинь. Харин тийм айн тэгээд Ганбат ах инээгээд байх юм.

Тэгэхээр саяын таны ярьж байгаа асуудлууд бүгд явж байгаа л асуудлууд. Тэгэхээр яамныхан нь хариулчихвал зүгээр юм биш үү?

**Д.Цогтбаатар:** Мягмар дарга.

**Н.Мягмар:** Одонтуяа гишүүний энэ шүүхийн шийдвэргүй баривчлахтай холбоотой хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан энэ хэрэгжиж байгаа юу гэдэг асуултад хариулъя. 2023 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд энэ хойшлуулшгүйгээр баривчлахтай холбоотой зохицуулалтыг тодруулж цагдан хорих болон шүүхийн шийдвэр дүгээр хойш шүүхийн шийдвэргүй яах вэ нөгөө хойшлуулшгүйгээр баривчлах энэ зохицуулалтыг илүү тодорхой болгож ингэж өгсөн. 2024 онд эрүүдэн шүүх конвенцын эсрэг тайланг бол Засгийн газрын тайланг бол энэ хороонд очиж тайлагнасан. Энэ үеэр бас энэ асуудлыг бол Засгийн газар Улсын Их Хурлаас энэ хууль тогтоомжийг шинэчлэн баталж хэрэгжилтийг нь мөрдүүлж эхлээд байна гэдэг тайлангаа танилцуулсан.

Энэ асуудал дээр бол ойлголтын зөрөө байгаа юм байна гэдэг зүйл дээр ер нь тогтсон юм. Өмнө нь бол яах вэ энэ нөгөө шүүхийн шийдвэргүй баривчлах гэдэг нь эхлээд нөгөө хойшлуулшгүй ажиллагаагаар баривчилчхаад дараа нь 24 цаг, 72 цагийнх.

**Д.Цогтбаатар:** Гүйцээгээд хариулъя 4 дүгээр микрофон.

**Н.Мягмар:** Шүүхэд материалаа бүрдүүлж байж шүүхийн шийдвэр гаргаж шүүхээс шийдвэр гараад цааш нь үргэлжлүүлж хорих гэдэг юм уу эсвэл суллах тэр шийдвэрийг гаргадаг байсан. Энийг орчуулгынхаа үед бол шүүхийн шийдвэргүйгээр баривчлах гэдэг агуулгаар явчихлаар огт ерөөсөө дур мэдэн дур зоргоороо баривчилдаг юм шиг ийм ойлголтоор конвенцын хороо ойлгочихсон юм байна. Тийм учраас энэ дээр бол энэ ойлголтын зөрөө байна гэдгээ бол бас тайлангийн хамгаалалтын үед бол ярьж байсан.

Тэгэхээр бас бидний хуулиар бол тодорхойгүй байсан зохицуулалтыг бол Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд нь тодорхой болгож өгч хорьж мөрдөх цагдан хорих хугацааны дээд хязгаарыг тогтоогоод өгсөн. Цагдаа хорих хорихгүй байх этгээд хорихгүй байх. этгээд өгч хориг мөрдөх хэдийн талаарх зохицуулалтыг илүү тодорхой болгоод ингээд өгчихсэн.

Тийм учраас энэ хууль бол яг цэвэр хууль сахиулах, цагдаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны байгууллагууд мөрдөж ажиллаж байгаа. Хууль бол хэрэгжээд явж байгаа гэж ойлгож байна. Хэрвээ энэнтэй холбоотой гомдол гаргах юм бол ХЭҮК өөр бусад прокурорт хэргийн оролцогч нар гомдол гаргах.

**Д.Цогтбаатар:** Одонтуяа гишүүнд микрофон өгье, тодруулъя.

**С.Одонтуяа:** Энэ бол бас зөвхөн ганцхан ойлголтын зөрөө бас биш байсан л даа. Энэ дээр энэ хууль батлагдсанаар жижүүрийн шүүхүүд ажиллаж эхэлсэн гэж би ойлгосон. Тэгэхээр ямар нэг асуудал гарахад жижүүрийн амралтын өдөр баяр ёслолоор жижүүрийн шүүхүүд энийг нь хянаж үзээд ингээд энэ нь бол бас нэг шүүхийн шийдвэрийн нэг хэлбэр болж байгаа юм уу л гэж бодсон. Тэр нөгөө олон улсын гэрээ конвенцуудтайгаа тулгалтуудаа хийж чадаж байгаа юу гэдэг асуулттай.

**Д.Цогтбаатар:** 4 дүгээр микрофон Мягмар дарга.

**Н.Мягмар:** Олон улсын гэрээ конвенцын хороодоос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд бол манай жишээ нь ХЗДХ-ийн салбарт хамаарах хууль тогтоомжоо бол нийцүүлэх чиглэлийг бол бид нар хийгээд явж байгаа. Одоо ялангуяа сая бид нар ХЗДХЯ-ны хэрэгжилтийг хариуцсан 2 конвенцын тайланг хамгаалсан. Үүнтэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг бол Засгийн газрын хуралдаанд танилцуулж төлөвлөгөөгөө батлуулчихсан. Энэ дээр бол зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагууд шүүх эрх мэдлийн чиглэлийн Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн сахилгын хороо гэх мэт АТГ, ХЭҮК чиглэлийн байгууллагуудын хариуцах ажлуудыг тодорхойлоод Засгийн газраас бол батлаад өгчихсөн байгаа.

**Д.Цогтбаатар:** Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

**Д.Пүрэвдаваа:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Хоолой өвдсөн байгаа шүү уучлаарай.

Хууль зүйн яамнаас асууя. Энэ нэг хуулийн хувьд нэг тайлбарлаад өгчихгүй юу. Бид нар Хууль тогтоомжийн тухай хууль гээд маш тодорхой хуультай иргэдээсээ саналаа авдаг тулгамдсан асуудлын судалгаа хийж байгаад эдийн засгийн болон нийгэмд үзүүлэх хор нөлөөг бүгдийг нь судалж байгаад тэгээд өнөөдөр хуулиа батлаад Их Хурлаас хууль тогтоомж шийдвэрүүд гаргаж байгаа юм. Тэгэнгүүт та бүхний тайлан дээр чинь хэрэгжүүлэх боломжгүй гэдэг ийм тайлан өгчхөж байгаа юм. Тэгээд хууль дээдлэх зарчим гэдэг юм чинь хаана гээгдээд байгаа юм бэ? Энд хууль батлаад тавьчихдаг боломжгүй гэдэг хариултыг өгч болж байгаа бол хууль батлах шаардлага байдаг юм уу? Энийг нэг аягүй тодорхой тайлбарлаад өгөөч ээ.

Дараагийнх нь асуудал дээр. Миний хамгийн сүүлд санаж байхад энгийнээр ингээд олон дарга ирчихсэн байгаа учраас та бүхнийг бол ажил хийгээгүй гэж хэлэхгүй. Тэгэхдээ маш их олон асуудлууд гардаг юм байна лээ. Тэгээд гишүүд учраас бичгээр болон биеэр олон санал гомдол ирдэг учраас жишээгээр Байгаль орчны яамнаас асууя. Танайх ингээд л хэвлэл мэдээллээр Төсвийн тухай хууль зөрчсөн гээд л маш их мэдээлэл ирж байна. Мэдээллийн ил тод байдал энэ Мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгждэггүй гээд тэгж байна. Та нэг товч жишээ татаад танай бүх шийдвэрүүд өнөөдөр хуулийн дагуу сайт дээрээ болон шийдвэр ил байгаа юу? Иргэн Пүрэвдаваа очоод авахад бэлэн үү? Энийг нэг хариулаад өгөөч.

Дээрээс нь Учрал Ерөнхий сайд хэлсэн. Одоо бид нар ингээд чөлөөлөх ёстой байна гэхээр өнгөрсөн хугацаанд чөлөөлөөгүй маш хаагдмал байсан байна л гэж ойлгоод байгаа юм. Тэгээд нөгөө 3 хоногт энэ төрийн ажил хийсэн ААН-үүдэд нөгөө санхүүжилтийг нь өгнө өө гэдэг шийдвэр гаргалаа өчигдөр. Тэгэхээр Сангийн яамнаас асууя. Энэ ер нь дунджаар энэ өмнөх хугацаанд энийг хийж болоогүй үндсэн 3 шалтгааныг нь нэг дурдаач.

Ерөнхий сайд хийж болдог юм байна гэдэг шийдвэр гаргачихлаа. Өмнө нь яагаад болоогүй гэсэн 3 шалтгааныг нэг дурдаад өгөөч гэж хүсмээр байна. Тэгээд энэ Нийгмийн хамгааллын төрийн нарийнаас нэг асуучихъя. Тэгээд тодотгол хийе гэхэд ингэж асууж байсан байхгүй юу. Манай дээр ингээд сул орон тоо хэдэн зуугаараа байдаг юм гэнэ. Нөгөө хууль биелүүлэх асуудлаа хаанаа гээчих вэ. Аубакир сайд хэвлэлээр маш тодорхой хэлчихсэн байхгүй юу. Манай дээр ингээд сул орон тоо байсан учраас бид нар ингээд хүмүүсээ халаагүй сайхан гэж.

**Д.Цогтбаатар:** Шууд авах уу эс үгүй бол. Эхлээд Хууль зүйн яам тэгээд дараа нь Байгаль орчны яам.

**Н.Мягмар:** Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Баталсан хуулийг хэрэгжүүлнэ. Засгийн газар бол хууль хэрэгжүүлэх үүрэгтэй. Тийм учраас бол хууль хэрэгжүүлэх боломжгүй гэдэг ийм тайланд орсон юмыг яг тодорхой жишээгээр яахгүй бол би яг хариулахад төвөгтэй байна. Ер нь бол Засгийн газар бол баталсан хуулийг хэрэгжүүлнэ. Парламент маань зарим хуулийг бол хэрэгжих хугацааг нь тодорхой тавьж өгдөг. Тэр тохиолдолд бол Засгийн газар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлаа хангадаг. Энэ хугацаандаа төсөв хөрөнгө хөрөнгө, оруулалттай холбоотой асуудал байх юм бол хэрэгжих хугацаагаа Засгийн газраас хойшлуулах саналаа оруулж ирж парламентаараа шийдвэрлүүлж ингэж л явдаг.

Түүнээс бусдаар бол хууль хэрэгжих боломжгүй гэдэг энэ зүйлийг бол тайлагнах бололцоогүй л гэж харж байна. Тэгээд яг энэ тайлан дээр хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг тайлагнасан гэдэг юм уу дүгнэсэн байгууллага нь л хэлэх нь зөв байх аа.

**Д.Цогтбаатар:** 6 дугаар микрофон.

**Ч.Бат-Эрдэнэ:** Гишүүний асуултад хариулъя.

ЗГХЭГ, ХШҮДАГ-ын дарга Бат-Эрдэнэ байна.

Энэ Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан журам байж байгаа. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийн хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам байж байгаа. Энэ журмын хүрээнд бол хэрэгжих боломжгүй агуулга дээр ямар шийдвэрүүд орох вэ гээд. Гишүүний асуусан тухайн заалт нь агуулга нь юу байсан бэ гэхээр Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл.

Тэгэхээр өнөөдөр яг энэ тайлагналт дээр бол энэ шийдвэрийн маань хугацаа дуусгавар болсон. Тэгээд хэмжигдэхүйц хэмжиж болохгүй байна гээд. Яагаад гэвэл энэ бол 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн асуудал яригдсан. Цаг хугацааны хувьд бол энийг үнэлэх боломжгүй байсан гэдгээр оруулж өгсөн. Тэгээд энэ дээр тайлан дээрээ бид нар энэ заалтыг хяналтаас хасъя.

**Д.Цогтбаатар:** 6 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

**Ч.Бат-Эрдэнэ:** ЗГХЭГ дээр бас энэ тайлангаа Их Хуралд өргөн барихтай холбоотойгоор нийтдээ энэ Хэрэг эрхлэх газар дээр 5600 заалтад хяналт тавигдаад явж байгаа. Тэгээд бид нар бол бас энэ заалтуудаас хяналтаас хасуулах энэ заалтууд цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болчихсон. Хэрэгжээд дууссан энэ заалтуудаа хасуулъя гээд бас 1500, 1600 заалтыг хасуулъя аа. Тэгэхгүй бол энэ өмнөх жилүүдэд энэ хяналтаас хасдаг энэ процесс хийгдээгүй юм байна лээ.

Тийм учраас энэ тайлангийн онцлог нь маань Их Хуралтайгаа хамтраад Байнгын хороо зөвшөөрөх юм бол энэ Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах энэ заалтуудаа бол хяналтаас хасуулах ийм саналтайгаар орж ирсэн байж байгаа.

**Д.Цогтбаатар:** Байгаль орчны яам 5 дугаар микрофон.

**Ш.Батбаяр:** Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Батбаяр байна аа. Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт хэвлэл мэдээлэл олон нийтийн хэрэгслээр яамны гаргасан тогтоол, тушаал шийдвэртэй холбоотой мэдээлэл дээр үндэслээд Төрийн нарийн бичгийн даргын албан даалгавар гаргаад дотоод хяналт шалгалт хийгдэж байгаа. Холбогдох хууль хүчний байгууллагууд мэдээллийг нээлттэй гаргаж өгч байгаа.

Хоёрдугаарт яамнаас гарч байгаа тогтоол, шийдвэрүүд, тушаал шийдвэрүүд бүгд хууль журмын дагуу гарч байгаа гэдгийг бас танд хэлье.

Гуравдугаарт, шилэн gov.mn болон шилэн данс дээр яам холбогдох бүх шийдвэрүүдээ цаг тухай бүрд нь оруулаад биелэлт 100 хувьтай явж байгаа.

**Д.Цогтбаатар:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэн байна? Мөнхзул дарга 5 дугаар микрофон.

**Л.Мөнхзул:** Гишүүний асуултад хариулья.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. Салбарын хэмжээнд 2025 оны улсын төсвийн тодотголтой холбогдуулан 9 хувийн орон тоо цомхотгогдох тийм хууль батлагдсан. Үүнтэй холбогдуулан салбарын хэмжээнд орон тоог 522-оор бууруулсан. Яг бодитой чөлөөлөгдсөн хүний тоо бол үүнээс нэлээд бага. Үндсэн асуудал нь юу вэ гэхээр тэтгэвэрт гарах насанд хүрсэн нэг удаагийн 36 сарын тэтгэмжийн хэмжээ суусан тохиолдолд тухайн албан хаагчтай харилцан тохиролцож саналыг нь аваад ингээд тэтгэвэрт нь суулгасан орон тоо дахиж нэмж аваагүй гэсэн ийм чиглэлүүдээр сул орон тоон дээр шилжүүлэн ажиллуулах замаар яг ажлын байрнаас халагдсан хүний тоог бага байлгаж чадсан.

Нөгөөтээгүүр салбарын хэмжээнд бол яг суман дээр ажиллаж байгаа нийгмийн халамжийн ажилтан.

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофон гүйцээгээд хариулья.

**Л.Мөнхзул:** Нийгмийн даатгалын байцаагч мөн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан зэрэг анхан шатан дээрээ ажилладаг эдгээр нэг нэг байдаг энэ албан хаагчдыг огт цомхотгоогүй ингээд бүгд ажлаа хийж байгаа. Тэгээд ер нь бол газар хэлтсийн дарга нарын тоо мөн түүнчлэн манаач, үйлчлэгч зэрэг нийтлэг чиг үүргүүдийг хасах чиглэл баримталсан. Мөн харуул хамгаалалтыг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх энэ чиглэлийг баримталж ажилласан байна.

**Д.Цогтбаатар:** Пүрэвдаваа гишүүн тодруулна гэсэн үү та.

Сангийн яам 5 дугаар микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулья.

Санхүүжилттэй холбоотой асуудал бол та бүхэн мэдэж байгаа. Мэдээжийн хэрэг орлоготой холбоотой асуудал байдаг. Орлогоор баталгаажуулах Их Хурлаар баталгаажуулаад зарлага тавьчихсан санхүүжилтийг Сангийн яам олгох ёстой. Гэхдээ энэ дээр бол хэд хэдэн шалтгаанаар энэ асуудал хойшилдог.

Нэгдүгээрт бол хөрөнгө оруулалтын хувьд бол тухайн барилгыг тухайн газар нутаг дээр Сангийн яамны бол мэргэжилтэн очоод бол биечлэн шалгах боломжгүй. Энэ ажлыг бол тухайн захиалагч төсвийн ерөнхийлөн захирагч хийдэг. Энэ процессыг хурдлуулсан тохиолдолд бид 3 хоногийн дотор олгох боломжтой гэдэг агуулгыг хэлж байгаа.

Хоёр дахь асуудал нь бол сая 2025 оны жилийн эцсээр бол орлогын бүрдэлт бол хүндэрсэнтэй холбоотойгоор урсгал зардлын санхүүжилт тодорхой хэмжээнд хязгаарлагдсан. Энэ асуудлыг бол бид нар 1 дүгээр улирлын байдлаар өнгөрсөн оны бүх өр төлбөрийг бол төлж барагдуулаад одоо бол төрийн сан бол хэвийн ажиллагаандаа ороод явж байна.

Энэ дээр бол мөн ялгаагүй төсвийн ерөнхийлөн захирагчдад бол яг батлагдсан төсвийнхөө хүрээнд гэрээ байгуулах, урсгал төсвөөсөө гэрээ байгуулах ийм шаардлага байгаа.

**Д.Цогтбаатар:** Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

**Д.Пүрэвдаваа:** Ингээдэхье. Сая нөгөө 3 шалтгааныг нэг нэрлээч ээ. Өмнө нь энэ чинь 3 хоногт шийдвэрлэнэ гэж яриагүй юмыг өчигдөр Ерөнхий сайд хэллээ шүү дээ. Бид нар ингээд яаралтай шийдэж болохоор шинэ тогтолцоог бий болголоо гээд. Тэгээд өмнө нь энийг яагаад хийх бололцоогүй байсан юм бэ гэдэг үндсэн шалтгаануудыг нэг тайлбарлаадахаа ч л гэж хүссэн юм. Тэгээд энгийнээр зүйрлэвээс одоо энэ төрийн албан хаагч нар шүүмжлэх та бүхний сонголт байхгүй юу даа. Ер нь ингээд энэ тайлан бичдэг бас энэ иргэдтэй нүүр тулдаг ААН-тэй нүүр тулдаг гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Гэхдээ хүнд суртал байгаа юу гэдгийг Ерөнхий сайд нь тодорхой хэлээд энэ төрийн хүнд суртал байгаа учраас энийг чөлөөлье өө гээд яваад байна шүү дээ. Тэгээд энэн дээрээ та бүхэн маань энэ хуулийн хэрэгжилт мэдээллийн ил тод байдал, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль.

**Д.Цогтбаатар:** Минут гүйцээгээд өгье.

**Д.Пүрэвдаваа:** Тэгэхээр би асуугаад байгаа юм. Яг энэ өдөр тутам та бүхний ширээний ном гэдэг шиг байнгын хэрэглэгддэг хуулиуд шиг энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль яам яаман дээр хэр хэрэгждэг юм. Сангийн яам энэ дээрээ нэг та яг нэг бодитоор нь хэлээд өгөөч. Түрүүний тэр байгаль орчны төрийн нарийн хэлэх ёстой байхгүй юу. Одоо ингээд энэ чинь олон нийтэд ил явж байгаа шүү дээ. Манай яам өнөөдөр ямар ч аж ахуйн нэгж иргэн ирээд манай тушаал шийдвэрийг шууд танилцах боломжтой гэдгээ хэлэхгүй бол огт боломжгүй байхгүй юу. Худлаа шүү дээ.

Улсын Их Хурлын танхим, Байнгын хорооны танхим дээр худлаа хэлж болохгүй. Хуулиараа зохицуулалттай. Яг өнөөдөр ингээд гомдлууд нь байгаа учраас хэлээд байхгүй юу даа. Тэгээд та өнөөдөр индэр дээр гарч байгаад тийм юм байхгүй гэдгээ хэлэх юм бол энэ ядаж иргэд чинь араас чинь очно шүү дээ.

**Д.Цогтбаатар:** Сангийн яам хариулах уу?

**М.Санжаадорж:** Төрийн хэмнэлтийн тухай хууль бол 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан нийт 22 зүйл заалттай. Эндээс 15 зүйл заалт нь бол яг хэмнэлттэй холбоотой асуудал. Бусад нь бол байгууллага албан тушаалтны үүргүүдийг заачихсан байж байгаа. Энэ 15-аасаа бол дийлэнх нь бол төсөв батлагдах үед бол барьж ажиллах горим байгаа. Нийтдээ 3, 4 бүлэг нь бол төсвийн гүйцэтгэлийн үед барьж ажиллах горим байгаа. Энэ горимыг бол манай яамны хувьд бол энийг хяналтаа тавиад явж байгаа. Ер нь энэ хууль дээр бол 2 байгууллага хяналт тавихаар заачихсан байгаа. Төрийн аудитын байгууллага болон Сангийн яам хяналт тавихаар заасан байгаа.

**Д.Цогтбаатар:** Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү за. Ганбат гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

Цаашдаа яах вэ зүгээр бид хэд нэг зүйлийг л бас ялгаж ойлгомоор байна аа. Хяналт шинжилгээ хийх хууль тогтоомжийн үр дагаварт үнэлгээ өгөх гэдэг чинь тэс ондоо юм байхгүй юу. Тэс ондоо юм. Тэгээд хуучин цагийн нөгөө ийм процессын хэм хэмжээн дээр явдаг шиг ийм юм хийгээд ингээд ийм юм хийгээд гаргасан хууль тогтоомжийг чинь хэрэгжүүлж чадахгүй гээд тайлагнаад сууж байгаа Засгийн газартаа харамсаж байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг Ерөнхий сайд болон кабинет энд хариуцдаг буюу хэрэгжихэд ийм хүндрэлүүд үүсээд байна гэдэг нөхцөлөө тайлагнадаг болохоос, хэрэгжүүлэх боломжгүй гэдэг тайлан илгээдэг. Ийм юм байж болохгүй байхгүй юу. Юу хэлээд байна гэхээр хяналт шинжилгээ хэрэгжилтийн үр дагавар гэдэг зүйлүүд тэс ондоо юм байгаа юм аа.

Тийм ч учраас Хяналт шинжилгээ мониторингийн газар энэ хууль тогтоомжийг хянадаггүй юм аа. Хууль тогтоомжийн агентлаг буюу энэ нийгэмд үзүүлж байгаа тэр нөлөөлөл, татварт, санхүүд үзүүлж байгаа төсөвт үзүүлж байгаа дарамт, хүний эрх, энэ зан үйлд үзүүлж байгаа хандлага, энэ орон тоо шаардаж байгаа тэр нөхцөл байдлуудыг дүгнэдэг байхгүй юу даа.

Би энийг сүүлийн ингээд 2, 3 жил хийж байна. Тэгээд одоо яг би Цогтбаатар даргын хэлж байгаа дээр санал нэг байна. Битгий ийм тайлан хэлэлцэх гээд ингээд энэ ТӨК-ийн захирлуудыг оруулаач ээ. Саяын чинь хууль тогтоомжийн хэрэгжилтийг асууж байна шүү дээ. Эрдэнэтийн 49 дээр. Захирал хариулахгүй. Захирал тэгэхээр доороо үүргээ аваад явна. Энэ хувьцаа эзэмшигчийн эрхийг хэн хэрэгжүүлж байгаа юм Эрдэнэс Монголын. Хэрэг эрхлэх газар биз дээ? Хэрэг эрхлэх газар хариулах ёстой байхгүй юу? Ингээд ТӨК улс төрөөс ангид байя гэдэг зарчмаа тогтоочоод ажил болохоороо ингээд түлхдэг. Бид хэд ерөөсөө энэ төрийн энэ хандлага ерөөсөө болохгүй байна. Тэгээд ер нь энэ одоо Эрдэнэтийн 49-тэй холбоотой асуудлыг хэрэгжүүлэхгүй гэж байна шүү дээ. Юу гэсэн үг юм бэ ийм байж болж байгаа юм уу нөхөд өө? Ийм хариуцлагагүй тайлан илгээхээд байж болж байгаа юм уу. Тэгээд гол гол асуудлууд дээр ерөөсөө ингээд асуудлуудаа хөндөж чадахгүй. Энэ чинь бид нарын нөгөө чих, нүдийг онгойлгож өгөх гээд байгаа байхгүй юу. Та хэдийн баталсан хууль чинь энэ дээрээ болохгүй байна зохион байгуулалт талаасаа. Энэ хуулийн текст нь угаасаа буруу гарчихжээ. Эсвэл энийг чинь хэрэгжүүлэх гээд тэгэхээр Сангийн яам болон эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын байдлаас ингэлээ шүү. Ийм юмыг чинь сонсоод дараа нь яах вэ гэдэг шийдэл энэ дээр ярих ёстой болохоос биш дүрэм журам гарсан уу гараагүй юу гэдэг юмыг ингээд уламжлалт энэ байдлаар явах юм бол бид нарт ямар үр дүн гарах юм бэ? Тэгээд энийг л маш олон жил хэлж байна.

Би Занданшатар даргыг засгийн газраа байгуулахад ч хэлсэн. Сая Учрал сайдыг байгуулахад ч хэлсэн. Ингэж байж та Ерөнхий сайд үүрэг даалгавраа өгнө өө. Ингэж байж та Улсын Их Хуралд энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж чадаж байгаа юу үгүй юу гэдгээ тайлагнах юм аа. Энэ цэвэр мэргэжлийн хүмүүс ажиллана аа. Тэрнээс биш хяналт шинжилгээ чинь биш шүү. Хяналт шинжилгээ чинь өдөр тутам байхгүй юу даа. Өдөр тутмын үйл ажиллагаан дээр цуглуулаад явдаг. Энэ хууль тогтоомжийн хэрэгжилт чинь дор хаяж нэгээс эсвэл хууль тогтоогчийн гэсэн хугацаа болоод дор хаяж 2-оос 3 жилийн хугацаанд гарч байж үр нөлөө үзүүлнэ. Тэгээд ийм юм боллоо. Энэ ингээд болохгүй байгаа учраас

дараагийн нэмэлт, өөрчлөлт оруулах ийм юмыг энэ тогтоол дээр жишээ нь хийх хэрэгтэй байна аа. Энэ хууль дээр ингэх хэрэгтэй байна.

Ийм юм ярина шүү дээ хэдүүлээ. Тэгээд одоо ийм юм ярьдаггүй ингээд аргалаад ингээд яваад байхаар энэ үр дүн гарахгүй байна. Хий бие биеийнхээ цагийг үрээд байна аа. Тэгээд том том шийдвэрүүдийг хэрэгжих боломжгүй, хуулийг хэрэгжүүлэхгүй гэдгийг тайлагнаж байна шүү дээ энэ чинь. Ерөнхий сайдын Засгийн газрын Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй гээд тайлагнаад ороод ирэхээр чинь юу гэж ойлгох юм бэ? Үндсэн хуулийн эсрэг тайлан болчихоод байна шүү дээ, томьёолол чинь. Би та нарыг үйлддэг гэж хэлээгүй шүү.

Тэгэхээр асуудлуудаа ерөөсөө ойлгохгүй байна гээд 2, 3 жил л яг энийг ярилаа. Тэгээд болдоггүй тэгээд л яг л ингээд л ороод ирэх юм. Нэг цаг хугацаатай л байдаг юм шиг байна. Тэгээд л ингээд аргалаад л ороод ирэх юм.

**Д.Цогтбаатар:** Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

**Б.Баярбаатар:** Өнөөдөр хэдүүлээ бас хууль хэрэгжүүлээд л сууж байгаа. Энэ тайланг хэлэлцэх ёстой учраас. Тэгээд би энэ дээр зориудаар хэлье. Одоо ингээд бусад Байнгын хороодууд хамаарах хүрээндээ энэ тайланг хэлэлцэх байх. Тэгээд энэ дээр энэ Их Хурлын Тамгын газар хяналт хэрэгжүүлэх, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тэр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх юу гэдэг юм тэр агентлаг юм уу юу юм тэр. Энэ 3 л орж ирээрэй. Тэр бусад дарга нарыг явж ажлыг нь хийлгэ. Та нар өөрсдөө асуултдаа хариул. Энэ яамдуудаа та бас нэгтгэсэн юм бол. Дээр нь би нэг хэлэлцэх асуудалдаа хамаарахгүй ч байж магадгүй. Зүгээр нэг зүйлийг хэлье. Би энэ төрийн албан хаагчийн 9 хувийн цомхотголыг анхнаас нь эсэргүүцэж байсан хүний нэг байгаа юм аа. Тэгээд энд өнөөдөр төрийн нарийнууд бүгд цугласан байгаа дээр би энэ нэг хүсэлт тавьчихъя. Энэ 9 хувийн цомхотголоор яг хэдэн хүн ямар албан тушаалтай, хэдэн хүн энэ цомхотголоор ажлаас чөлөөлөгдсөн бэ гэдэг мэдээллийг надад ирүүлээч ээ бичгээр.

Хэдэн дарга, хэдэн даргын үүрэг гүйцэтгэгч цомхотгож тийм төсөвт тийм хэмнэлт авчирлаа гэж. Яах вэ би энэ талаараа бас нөгөө агуулгаар нь гэх юм уу би мэдээлэл авчирсан байгаа учраас би бас давхар та хэдээс яг албан ёсны мэдээлэл авмаар байна. Төрийн нарийнууд энийг нэг та бүхэн 7 хоногийн дотор надад нэг ирүүлж өгөөч. Харьяа агентлагуудаасаа аваад. Яг л бодит мэдээллийг бас та бүхнээс авъя гэж хүсэж байна.

Тэгээд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Их Хурлын хяналт шинжилгээний хэлтэс билүү та хэд маань нэг сууж байгаад энэ нэг аргачлал дээрээ би өнгөрсөн жил энийг бас л хэлж байсан юм. Энэ жил дахиад л хэлье. Энэ аргачлал дээрээ нэг дахиж хараач ээ. Бид нар энэ хэдэн яамдын удирдлагууд төрийн албан хаагчид энэ үнэлгээ хийж байгаа аргачлалаас чинь болоод бас зэмлэл хүртээд баймааргүй байна аа.

Тийм учраас энэ чинь арга нь болохгүй байгаа учраас л энэ гишүүдийн уурлаад байгаа зүйл шүү дээ. Тэрнээс өнөөдөр энэ олон яам агентлагуудыг ажлаа хийхгүй байна гэж хэлээд байгаа зүйл огт байхгүй. Хууль хэрэгжих ёстой учраас бид нар өнөөдөр хэлэлцээд сууж байгаа гэдгийг би хэлсэн эхэндээ. Нөгөө талаараа бол цагийн гарз л болж байна яг ний нуугүй хэлэхэд. Хууль зүйн техник талаасаа Сайнзоригийн хэлж байгаа зөв л дөө. Энэ чинь яг деталь нарийвчлаад үг

өгүүлбэрээр нь яривал энэ дотор чинь асар олон асуудалтай зүйлүүд байна. Тэгээд тэр бүрийг яриад яах вэ. Зүгээр ерөнхий хэдүүлээ нэг ийм сайжруулах тал дээрээ, агуулга тал дээрээ хэдүүлээ анхаарч ажиллах зайлшгүй шаардлага байна.

Тэгэхээр би дараа дараагийн Байнгын хороодын хурал дээр би өөрөө ч зарим Байнгын хороод дээр нь орно. ЗГХЭГ, Их Хурлын хяналт хэрэгжүүлэх газар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар гэсэн энэ 3 газар л орж ирээрэй. Бусад яам агентлагууд ажлаа хийцгээ. Одоо сая тэр Усны газрын дарга Батбаяр дарга сууж байна. Юу хийж яваа юм энд. Ажлаа хийх ёстой шүү дээ. Ийм саналтай байна дарга аа.

**Д.Цогтбаатар:** Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

**Х.Баасанжаргал:** Би яг нөгөө өмнөх 2 гишүүнтэйгээ адилхан яг энэ тайланг дараагийн удаа нэлээн үр дүнтэй байлгах талаас нь хаа хаанаа анхаараад Хяналт хэрэгжүүлэх газар, Улсын Их Хурлын энэ Хяналт шинжилгээ дүн шинжилгээний газар ч гэсэндээ анхаараад яг дараагийн удаа бид нар ийм тайлан сонсмооргүй байна аа.

Хоёрдугаарт харин Байнгын хорооны даргад хэлэхэд бид нар энэ тайланг дараагийн удаа өөрсдөө Байнгын хороо дангаараа сонсохгүй, иргэдтэйгээ хамт сонсмоор байна гэдэг ийм горимын саналтай байна гэсэн үг. Энэ тайлан 1 дүгээрт олон нийтэд нээлттэй баймаар байна. Иргэний нийгэм ТББ иргэд энэ тайлантай танилцчихсан баймаар байна. Энэ сонсголыг бид нар энэ сонсох үйл ажиллагаагаа нээлттэй хэлэлцүүлэг байдлаар хийх юм уу яах юм гээд. Ингээд форматын хувьд арай өөр байдлаар хиймээр байна гэсэн үг. Тэгэхээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг сонсоод бид нар сонсоод л дуусгачихна шүү дээ.

Тэгэхээр яг энэ сонсохдоо бид нар илүү яаж олон нийтэд нээлттэй, илүү яаж олон нийтийн оролцоотой илүү яаж иргэний нийгэм ТББ-ын оролцоотой байх вэ гэдэг талаас нь формат талаас нь бас манай Байнгын хороо анхаармаар байна гэсэн үг. Би сая хуулийг харлаа. Хууль дээр нэг их айхтар хязгаарлалт ерөөсөө байхгүй. ХЗБХ сонсоно гэж байна. Тэгэхээр манай Байнгын хороо өөрсдөө л энийгээ шийдээд явчих боломжтой гэж харж байна.

Тэгэхээр дараагийн удаа тайланг зөвхөн ингээд хэдхэн тооны гишүүдийн хүрээнд гэхгүйгээр яг энэ ер нь бол энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудал дээр иргэд ямар байр суурьтай байгаа юм та хэд энэ тайлантай үзэж хараад танилцаад энэ чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд ямар коммент хэлэх нь вэ, ямар санал хэлэх нь вэ гэдгийг бас бүгдээрээ сонсмоор байна гэсэн ийм саналтай гэсэн үг. Тэгэхээр дараагийн удаа зохион байгуулалт дээрээ анхаараад явъя гэсэн үг. Уг нь би энэ тайланг ч гэсэн тэгж сонсмоор байна гэдэг горимын санал гаргая гэсэн боловч нэгэнт энэ хүртэл энэ олон хүмүүсийн цаг завьг үрчхээд ингээд горимын санал гаргаад хойшлуулахаар бол бас арай боломгүй болчихоод байна гэсэн үг ээ.

Гуравдугаарт илүү агуулга руу нь оръё. Агуулга дээр 2 санал байна.

Нэгдүгээрт энэ юм л бол энэ шүүх рүү бурууг чихдэг. Хэрэг эрхлэхийн сайд аа. Яг энэ тайлан дээр энэ тайлан дээр Эрдэнэт үйлдвэртэй холбоотой энэ хэрэгжих боломжгүй заалт гэдгийн хойно дүн шинжилгээ хийсэн тайлбар дээр нь шүүхийн

шийдвэртэй холбоотой нэг ч үг, үсэг байхгүй байна. Цэцийн шийдвэртэй холбоотой нэг ч үг, үсэг байхгүй байна.

Эсвэл энэ дүн шинжилгээ хийхдээ эсвэл дутуу хийсэн гэсэн үг юм уу. Хяналт хэрэгжүүлэх газар нь. Тэгээд яг ингээд хэлж байгаа тайлбар ирсэн тайлан бичвэр 2 хоорондоо зөрөөд байна аа. Тэгэхээр энэ Эрдэнэт үйлдвэртэй холбоотой хэрэгжих боломжгүй нэг заалтын асуудлыг нэг тухайлаад сая Байнгын хорооны дарга хэллээ.

Энэ дээр асуудал ярих ёстой байх гэж бодож байна. Эсвэл бид нар хүний хөрөнгийг мөнгийг нь өгөхгүйгээр эсвэл дээрэмдэж авсан, эсвэл энийг нэг талд нь гаргах ёстой. Ямар ч байсан нэг талдаа болох ёстой. Тэгэхээр энэ асуудлыг нэг тодорхой болгохгүй бол хэрэгжих боломжгүй гэж орж ирээд тэгээд сүүлдээ хэрэгжих боломжгүй заалтуудыг хяналтаас гаргая гээд тэгээд сүүлдээ хяналтаас гараад юу болсон нь мэдэгдэхгүй л нэг ийм юм руугаа л орох гээд байна л даа. Нөгөө нохойн зам руу л орох шинжтэй л болох гээд байна л даа.

Тэгэхээр ийм зүйл байж болохгүй гэж бодож байна. Тэгэхээр энэ хэрэгжих боломжгүй заалтуудыг хяналтаас гаргахдаа манай Их Хурлын энэ Хяналт шинжилгээ үнэлгээний газрынхан ч гэсэн дээ энэ дээр бас тодорхой хэмжээний хяналт шалгууртай байж байж ямыг нь хяналтаас гаргах юм. Ямыг нь яах юм гэдгийг тун серъёзны ярих ёстой шүү гэдгийг хэлье гэсэн үг. Ганцхан энэ Эрдэнэт үйлдвэрээр л жишээ болгож авч байгаа гэсэн үг шүү дээ? Тэгэхээр өөр бусад сая 5 мянга хэдэн 100 заалтыг хяналтаас гаргая гээд тэрэн дотор үнэхээр цаг хугацаа хоцорсон эсвэл өөр цаана нь янз бүрийн лоббины асуудал өөр янз бүрийн асуудал байх вий гэж жоохон санаа зовж байна гэсэн үг. Энэ дээр нэг тухайлан анхаарах ёстой гэсэн үг.

Хоёрдугаарт анх агуулгын хувьд анхаарах ёстой бас нэг бүлэг асуудал бол юу вэ гэвэл энэ хүний эрх эрх чөлөөний баталгаатай холбоотой зохицуулалт. ХЭҮК-ын тайланг Их Хурал сонсдог. Их Хурлаас тогтоол гардаг тогтоолын хэрэгжилттэй холбоотой энэ асуудлыг бүүр тусгайлаад бид нар нэг хэлэлцмээр байна. Би Хяналт хэрэгжүүлэх газрынхан энэ дээр нэг тайлан гаргасан юм. Энийг бүүр Хууль зүйн байнгын хороогоороо сонсмоор байна. Хүний эрхийн дэд хороогоороо сонсмоор байна. Энд өөр хэн ч оролцдог субъект өөр ямар ч субъект байхгүй. Засгийн газар тэр Их Хурлын гаргасан тогтоолыг яагаад хэрэгжүүлэхгүй байгаа юм, юу нь болохгүй байгаа юм? Бид нар тэр хүний эрх, эрх чөлөөний бүтэн жилийн тайланг аваад сонсоод тэрний үр дүн.

**Д.Цогтбаатар:** Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

**Д.Пүрэвдаваа:** Хэрэг эрхлэх газрын хамт олонд бас нэг хандаад хэлмээр байна аа. Нөгөө нэг хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй. Хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй гээд нэг логик байгаа шүү шүү дээ. Тэгэхээр зэрэг тайлан чинь дийлэнх нь ийм дүгнэлт нь бага тайлан дийлэнхдээ ийм хүүрнэсэн өгүүлбэрээр тайлагначихсан байна аа.

Тийм учраас аль болохоор тоо статистик үр дүнд суурилсан энэ тайлагналтын системийг нэвтрүүлмээр байна гэж хэлэх байна.

Дараагийн дугаарт хариуцлагын асуудал тодорхойгүй байна. Ялангуяа хууль хэрэгжүүлэхгүй байж болж байна. Түрүүний жишээгээр татахад энгийнээс жишээ

байна шүү дээ. Орон тоог нь баталчхаад байхад бид нар хүн авахгүй байж болж байна шүү дээ. Уул нь орон тоо батлагдсан дүнгээрээ байх ёстой. Тэгээд зарим яаман дээр архидан согтууралт болж байна л гээд л тэгж байна. Дийлэнх яамдууд дээр үүрэг гүйцэтгэгч нар хавсарч ажил хийдэг асуудлууд байна. Одоо нэг хэлтсийн даргын шалгуурыг хангадаг нөхөр давхар дээд албан тушаалаа ч гэдэг юм уу Тамгын даргаа ч юм уу хавсран гүйцэтгэдэг нэг ийм хууль зөрчиж байгаа асуудал маш их байна. Энэн дээр ямар үр дүн хийсэн юм? Ямар тайлагналт хийсэн юм? Ямар илүү зардал гараад байгаа юм гэдгийг ер нь ингээд Хэрэг эрхлэх газрын дарга энийг бичгээр авч болох уу? Тэрийг нэг асуумаар байна.

**Д.Цогтбаатар:** Номинчимэг гишүүн энд Хэрэг эрхлэхийн даргаас хүн юм асуугаад байна.

**Д.Пүрэвдаваа:** Цаг ингээд өнөөдөр нөгөө хугацаа нь бага байсан учраас энэ даргад байдаг нөгөө хүний нөөцийн нүүдэл буюу энэ хууль дээдлэх зарчим батлагдсан төсвийн хүрээнд боловсон хүчнээ бэлтгэж авах ёстой шүү дээ ТАЗ-тэйгөө хамтраад. Тэрийгээ хэрэгжээгүй улсууд дээр ямар хэмнэлт гарсан юм ямар илүү зардал гарсан юм ямар үр дүн тооцсоныг авмаар байна. Тэгээд түрүүний бас сөхөгдлөө иргэдийн оролцоо маш чухал байна аа. Бид хуулийг нь батлаад өгчихдөг. Та бүхэн маань хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй байгаад байдаг. Гэтэл яг та бүхний шийдвэрээр үйлчилгээ авч байгаа нь иргэд ААН-үүд. Тэгэхээр тэр иргэд ААН-ийн санал, дүгнэлт хаана тусгагдаад байгаа юм бэ? Бид нарын үйлчлүүлэгч нар чинь иргэд байгаа шүү дээ. Ялангуяа энэ яам Тамгын газраар тогтмол үйлчлүүлж байгаа улсууд бол ААН-үүд, иргэд. Тэдгээрийн санал хаана явж байна тэдгээрийн дүгнэлт хаана явж байна. Энийг бас тусгаж өгөөч гэж хүсмээр байна.

Тэгээд одоо энгийн жишээ. Энэ Сангийн яамны төрийн нарийн нь байхгүй хаана яваа юм уулзмаар байна. Уул нь ингээд өнөөдөр ирчихсэн байвал. Оюу толгойн тэр мөнгө орж ирээгүй байсан бол манайх төсвийн алдагдал хэдэн хувьтай явж байгаа юм. Энэ чинь өнөөдөр алдчихна гэж тооцоогүй, өмнөх асуудлууд байгаа шүү дээ 2025 оны. Ингээд яг нарийн юм асууя гэхээр бөөрөнхийлдөг. Төрийн албан хаагч нарыг. Бөөрөнхийлдөг асуудлуудыг хэн рүү хандах юм. Би үг хэлж байгаа юм. Тэгэхээр та бүхэн маань нэг бас нэг жоохон сэтгэл гаргаад төрийн албанд би бас тодорхой хэмжээнд ажиллаж байсан учраас яаж ийж ийм бөөрөнхий хариулт өгөх тэр ухаанаа та бүхэн үнэхээр чадна. Тэгэхдээ сэтгэл гаргаад юмыг тодорхой байя, ойлгомжгүй юу гэдэг юм.

**Д.Цогтбаатар:** Ганбат гишүүний микрофоныг өгье.

**Д.Ганбат:** Энэ ийм л байна л даа. Бид нар энэ Их Хурлаас гарсан шийдвэр хэрэгжээд Засгийн газар хэрэгжүүлээд тэгээд улс орон маань ийм байгаа бол их л харамсалтай л байна. Тэгээд бараг гучаад хувийн ядууралтай 20, 30 жил байсан тэгээд л тэр хэвээрээ л байх юм. Тэгээд 1 болж байгаа бүтэж байгаа салбар алга л даа. Тэгэхээр энэ Их Хурлаас гарч байгаа шийдвэрүүд тогтоолууд буруу гараад байдаг юм уу эсвэл гарсан тогтоол шийдвэр нь хэрэгжихдээ ингээд дутуу яваад ингээд хэрэгжихдэг юм уу яадаг юм. Нэг л сонин л байна л даа. Тэгээд 3 Засгийн газар энэ бүрэн эрхийн хугацаанд үзчих шиг боллоо. Эхнийх нь олон мега төсөл хэрэгжүүлнэ гээд л байсан тэгээд л эсрэгээрээ л мега хулгай луйвар яриад л болчихлоо.

Дараагийн Засгийн газар нь цэгцэрнэ л гээд байсан тэгээд нэг их цэгцэрч чадсангүй байж байгаад л огцорчхож байгаа юм. Одоогийн Засгийн газар чөлөөлье л гээд байх юм. Хэрэв чөлөөлнө гэж байгаа бол битгий л ахиад нөгөө 2 Засгийн газрынх шигээ эсрэг болчхоосой доо. Нөгөө авлига хулгай ял малаа л чөлөөлөөд явчих вий гэсэн иймэрхүү болгоомжлолууд байна л даа. Тэгээд их олон төрийн албан хаагчид байдаг юм байна. Би өөрөө миний төрсөн ах дүү нараас нэг төрийн албанд ажилладаг хүн байхгүй. Манай хүүхдүүд ч гэсэн ажилладаггүй. Тэгээд энэ төр засаг уул нь зөв ажиллуулбал их үр дүнтэй ажиллаж болно л доо. Тийм үр дүнтэй ажиллаж чадахгүй л байх шиг байна. Би тухайн үедээ ажил хариуцаад л байж байхдаа хэд хэдэн тогтоол шийдвэрүүдийг гаргадаг байсан АН олонх байхад. Тэр алтны талаар шийдвэр гаргаж л байлаа. Тэрний үр дүнд хорин хэдэн тонн алт авдаг л байлаа. Энэ Эрүү, Зөрчлийн хуулиудыг би ажлын хэсгийг нь ахалж гаргаж байсан юм.

Яг хамгийн сүүлийн ганц нэг хуулийн бэлэн болгочоод байхад нөгөө Ардын нам руу шилжүүлсэн тэгээд л тэр нь тэгээд л болсон болоогүй нэг хачин юм болоод л явчихсан юм. Намайг Хууль зүйн байнгын хорооны дарга хийж байхад энэ улс орон чинь авлигын төсөөллийн индексээр л далан хэдэд байсан шүү дээ. Одоо бүр 2 нугараад 120 хэдэд орчихсон байна гэх мэтчилэн. Одоо энэ засаг төр чинь тэгээд энэ цахимжиж байна гээд л цахим яамтай л юм байна. Хиймэл оюун ухаан гээд AI гээд хаа сайгүй бий болчихсон байна. Энэ мэнийг ашиглаж байгаа хэрэглэж байгаа ийм юм байна уу, байхгүй юу айн? Хэрэв тэрүүгээр үнэлүүлээд ингээд гаргах юм бол энэ үнэлгээнүүд чинь шал эсрэгээрээ л гарах байх ийм л байх юм. Тэгээд бид нарын бас нэг ойлголт өөрчлөгдмөөр байгаа юм аа. Маргарет Течер юу гэж хэлж байсан бэ гэхээр ерөөсөө л Англи улсын Засгийн газар танд туслахаар ирлээ. Ийм л үг хэн ч битгий насан туршдаа сонсоосой энэ Английн иргэд гэдэг байсан байхгүй юу. Одоо энэ Монгол Улсын иргэн болгон л Монгол Улсын Засгийн газар ирээсэй л гэж байх шиг байна. Тэгээд очихгүй байна л даа бүгдэд нь хүнд байна. Хажууд сууж байх шиг байна зарим нь.

Тийм тэгээд энэ Хууль зүйн сайд хийж байсан хүнийгээ л бас яагаад ч юм тэгээд нэг мэргэшүүлэхгүй овоо ажил төрлөө хийгээд л байж л ахиад л Хэрэг эрхлэхийн дарга гээд л явчих юм тэ? Би ерөөсөө ойлгохоо байчхаад байгаа юм. Яах вэ Засгийн газар хажууд сууж байна гэхээр л ярьж байгаа юм л даа. Нэг ийм байгаа юм нөхдүүд ээ.

Тэгэхээр одоо ажил төрлөө сайжруулах хэрэгтэй байна. Энэ ард түмний амьдрал ахуй чинь их хүндэрч байна шүү. Ийм сайхан залуучууд муу л удирдлага байна уу гэхээс биш муу боловсон хүчин байна гэж байхгүй л дээ. Та нарыг бол нэг их буруутгаад энэ тэр байх.

**Д.Цогтбаатар:** Би нэг товчхон хэдэн үг хэлчихье. Гишүүд ер нь үг хэлж дууслаа.

Нэг хэдэн зүйл хэлмээр байна.

Нэгдүгээрт Энхбаяр сайд ингэх хэрэгтэй. Хууль зүйн байнгын хорооноос яг эрх зүйн чиглэлээрээ бид нар мэргэшсэн Байнгын хорооны хувьд ийм нүсэр армитайгаар та явж 11 Байнгын хороогоор ийм юм хийж болохгүй шүү. Энэ хүмүүсийн ажлын цаг, энэ хүмүүсийн ажлын цаг гэдэг чинь цаана нь иргэдэд үйлчлэх тэр үйлчилгээний цаг л хоргодож байгаа гэсэн үг. Нэг бичиг, нэг иргэний

асуудлыг шийдэх бичиг гарах нь л хойшилж байгаа гэсэн үг шүү дээ. Тэгээд бүгдээрээ энд ингээд суугаад л бярыг үзүүлээд л ингэх ямар ч шаардлага байхгүй. Аягүй ажил хэрэгч цомхон яг салбар салбарын юунуудтайгаа очих хэрэгтэй байх шүү, нэг.

Хоёрдугаарт одоо эндээс би ингээд харж байхад нөгөө би хамгийн түрүүнд төр дэндүү том болсон байна гэдэг асуудлыг хүмүүс ерөөсөө ярихаа больчихсон байхад энийг би гаргаж ирж тавьж байсан. Яг бодит байдлаар харин та бүрэн тоогоор нь ингээд аваад ирэхээр нүсэр байгаа чинь харагдаж байна. Нүрлийсэн олон хүн оруулж ирээд энүүгээр нэг суулгачихсан байж байна шүү дээ. Манай Засгийн газар байна шүү дээ АНУ-ын Засгийн газар кор министрес гээд үндсэн яг яамтай сайд нараа аваад үзэхлээр 15 шүү дээ. Бид нараас 100 дахин том улс байж байгаа шүү дээ. Тэгэхэд манайх ямар Засгийн газартай байгаа вэ. Тэгээд ийм юман дээрээ цаашдаа тэр бодлогоо боловсруулахдаа сая боловсон хүчний асуудал ч яригдаад байна. Энэ мэнийгээ тал талдаа бодож байх хэрэгтэй байна. Засаг их том болсон байгаагийн чинь шинж одоо яг эндээс ингээд харагдаж байгаа юм аа. Тэгэхлээр нэг л асуудалд их сүржин, сүржин, том том юм яриад байх биш асуудлыг жижигхэн яг газар газар дээр нь шийдээд явах тэр чадварлаг боловсон хүчинтэй л бид нар байх ёстой. Түрүүн Баасанжаргал гишүүний энэ яриад байгаа яг бодитой үр дүн гаргах юман дээр бол энэ удаагийн хурал дээр би ингэж бодож байна. Гишүүдийн бүх хэлсэн санаануудыг түүж аваад Байнгын хорооноос. Холбогдох яамдууд руу гэхдээ би гишүүддээ бүгдээрэнд нь үзүүлнэ. Тэгээд саналаа өөрсдөө тэрэн дээрээ хэлээд. Тэгээд холбогдох яамдууд руу энэ энэ чиглэлээр гишүүд юу санал тавьсан шүү. Энийг анхаарч ажиллаарай гээд. Энийгээ ил тод тавина. Өөрөөр хэлбэл сая Баасанжаргал гишүүн олон нийтийн бас оролцоотой байх ёстой юм биш үү гэдэг асуудал тавьж байна шүү дээ.

Тэгэхээр ямар ч гэсэн энэ удаагийн хурал бол яамдууд руу явах бичиг бол олон нийтэд бүгдээрэнд нь ил бид нар тавьж байгаад явуулна. Зүгээр харин тэр олон нийт оролцуулж дараагийн хурал хийх үү гэдэг дээр би бол нээлттэй байна.

Дараагийн хурал өөр даргатай Байнгын хороо энэ чинь нөгөө ротацтай учраас хийгдээд явах байх. Тэр үедээ ярина биз. Миний хувьд нээлттэй байна. Харин нэг асуудал байгаа юм. Зүгээр одоо ингээд гишүүдэд тайлан нь хугацаандаа тараасан тараагаагүй гээд л одоо сая яригдаж байна шүү дээ. Тэгэхэд бид нар хугацаанд нь тараагаад явсан байхад л энэ асуудал гарч байна шүү дээ. Тэгтэл нөгөө иргэд чинь бол орж ирэх хүмүүст бид нар хэзээ яаж тараах вэ гэдэг асуудлаас авхуулаад техникийн асуудлууд гарна. Тэрийгээ тэгээд тухайн үедээ ярьцаагаад шийднэ биз. Би бол нээлттэй байна. Ямар ч гэсэн таны саналыг энэ удаа хэрэгжүүлж болох боломжийнхоо хүрээнд би бол хэрэгжүүлээд явна гэдэг юугаа саналаа хэлмээр байна.

Саяын тэр Эрдэнэтийн асуудалтай холбоотойгоор нэг зүйл хэлмээр байна. Засгийн газар энэ дээр бодоогүй байна шүү. Тэгэхээр Засгийн газар энэ шийдлийг эрх зүйн шийдлийг бодоогүй одоо болтол яваад тэгээд энэ шийдэлгүй гээд орж ирж байж ерөөсөө болохгүй. Тэгэхээр одоо дараагийн удаа бол энэ дээр ёстой тэр ажлын хэсгээ гаргах уу яах вэ? Энэ дээр бид нар нэг шийдэл бодож олох ёстой суугаад бодоцгоо. Шийдэлгүй эрх зүйн асуудал гэж байх угаасаа ёсгүй.

Тийм учраас энийг та нар тал талдаа бодож үзээрэй гэж хэлмээр байна. Энийг ч гэсэн бид нар явуулах бичигтээ дурдаад явуулъя. Баярлалаа.

Өнөөдөр ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Хууль тогтоолоор үүрэг чиглэл болсон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Гишүүддээ баярлалаа.

12.30 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА